

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2021 · 03 сар | Дугаар 28

ГАРЧИГ

- 2-3** Хадгаламж, зээлийн хоршооны онцлог, эдийн засагт гүйцэтгэх үүрэг
- 3-7** Зохицуулалтын мэдээ
- 8-10** ХЗХ-ны зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх нь ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй
- 11** Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам
- 11-13** К р и п т о в а л ю т ы н зохицуулалтын олон улсын туршлага
- 14** Тогтвортой санхүүжилт
- 15-18** Австралийн санхүүгийн зах зээлийн реформ
- 19** Өргөн дуран
- 20** Санхүүгийн боловсрол
- 21-22** Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 онд анхаарах асуудлууд /2-р хэсэг/
- 22-23** Зах зээлийн мэдээ
- 24** ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 8 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- 9 +976-51-264444
- 10 press@frc.mn
- 11 www.frc.mn
- 12 Санхүүгийн зохицуулах хороо
- 13 @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Дэлхий нийтэд тулгараад байгаа байгаль орчин, хүрээлэн буй орчны доройтол, байгалийн нөөцийн хомсдол, хүлэмжийн хийн ялгарал, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудын талаарх мэдээллийг сонсоод хүн бүр санаа зовнидог ч экологийн үл мөрөө аль болох бага байлгахад биднээс нэлээдгүй хүчин чармайлт гарах учраас тэр бүр хариуцлагатай байж чаддаггүй.

Тогтвортой санхүүжилт нь хүн болон компанийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх үл мөрийг хамгийн бага байлгахад гол хөшүүрэг нь болдог. Хэрэв тийм бол, тогтвортой санхүүжилт гэж юу вэ? Уг ойлголт нь урт хугацаанд оршин тогтнох, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хүчин зүйлсийг тэнцвэртэйгээр хөгжүүлэхэд хөшүүрэг болсон санхүүжилт олгоход тухайн төсөл эсвэл бизнес нь байгаль орчин, хүний таатай аж төрөх нөхцөлийг бүрдүүлж буй эсэхийг шалгуур болгон үнэлэхийг хэлнэ.

Иргэд, аж ахуйн нэгжүүд ногоон үйлдвэрлэлд шилжих шилжилтийг нэмэлт зардал гэж хардаг бол уг хандлагыг эвдэх, ногоон үйлдвэрлэл болон хэрэглээнд шилжихийг өртөг бус, харин шинэ боломж болгох арга нь тогтвортой санхүүжилт юм.

Хэрэв тийм бол, танд бизнесийн сайхан санаа байдаг боловч түүнийг ажил хэрэг болгоход санхүүжилт олдохгүй байна уу? Шинэ төслийн санаагаа ногоон эдийн засагт нийцүүлж хийвэл санхүүжилтийн олдоц нэмэгддэг гэдгийг та бодож үзсэн үү?

Манай Улсын хувьд тогтвортой санхүүжилтийг арилжааны банкууд санаачлан Монголын банкны холбоон дээр 2013 онд бүх банкны төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулж улмаар 2015 оноос эхлэн нэгдсэн байдлаар бүх арилжааны банкууд зээл олгоходоо байгаль орчин, нийгэмд ээлтэй байдлын үнэлгээг хийдэг болсон. 2020 онд арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооны нийт олгосон зээл 18.6 их наяд төгрөг байгаа бол Монголбанкнаас гаргасан



ногоон зээлийн тайланд тус онд нийт 2,463 ногоон зээлд 48.4 тэрбум төгрөгийг олгосон ба үүнээс бизнесийн байгууллагад 95 хувь, иргэнд 5 хувь нь хуваарилагдсан байна. Тогтвортой санхүүжилтийн уг зээлээс нийт 8 салбарын байгаль орчин, нийгэмд ээлтэй бизнес, төслүүдийг дэмжсэн нь дараах байдалтай байна:

- Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ 54%;
- Ногоон барилга 25.8%;
- Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлал 13.3%;
- Эрчим хүчний хэмнэлт 3.2%;
- Карбон бага тээвэр 2.0%;
- Бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагаа 1.1%;
- Бага бохирдуулагч эрчим хүч 0.5%;
- Сэргээгдэх эрчим хүчний салбарт 0.2%.

Таныг санхүүгийн байгууллагаас зээл авахад орлогыг тань баталгаажуулж, зээлсэн санхүүжилтээ буцаан төлөх чадвар, санхүүгийн сахилга бат гэсэн нийтлэг шалгуурыг харгалзан үздэг. Тэгвэл тогтвортой, ногоон зээл нь уг шалгуур дээр байгаль орчин, нийгэмд ээлтэй байдлыг хангасан байхыг шаарддаг.

Үргэлжлэл 14-р нүүрт >>



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

“Энгийн хувьцаа:

Компанид тодорхой хувь эзэмшин, эзэмшсэн хувь хэмжээгээр саналын эрх эдэлж, ногдол ашиг болон хөрөнгийн үнэ цэнийн өсөлт хэлбэрээр эдийн засгийн өгөөж хүртэх эрхтэй хувьцааны төрөл.”



“Common stock:

Securities representing equity ownership in a corporation, providing voting rights, and entitling the holder to a share of the company's success through dividends and/or capital appreciation.

“Эх сурвалж:

Банк санхүүгийн тайлбар толь бичиг



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ОНЦЛОГ, ЭДИЙН ЗАСАГТ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Санхүүгийн хоршоо буюу хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) анх XIX зууны эхэнд Европ тивд үүссэн гэж үздэг. Тэр цагаас хойш олон жил өнгөрсөн ч ХЗХ-ны анхны агуулга, зарчим утга санаа, зорилгоо алдаагүй хөгжсөөр байна. Хоршооны эцэг гэж нэрлэгддэг Фридрих Райффайзен гэж хүний гаргасан “ХЗХ-ны үйл ажиллагаа зөвхөн зээл олгосноор хязгаарлагдах ёсгүй. Эрхэм зорилго нь гишүүдийнхээ санхүүгийн байдлыг дээшлүүлэх, хөрөнгөө хэрхэн зарцуулж байгаад хяналт тавих, тэднийг өөр

хоорондоо хамтран ажиллах хүсэл зоригийг дээшлүүлэхэд оршино” гэсэн үзэл баримтлал эдүгээ ч үнэ цэнээ хадгалсаар байна.

ХЗХ нь олон улсын хоршооллын зарчмын дагуу иргэдийг гишүүнчлэлд хамруулахдаа тухайн бүс нутагт хамтын удирдлага, хяналтын тогтолцоог хөгжүүлж, иргэдийн хуримтлал бий болгох хандлага болон бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих үйл ажиллагаа явуулснаар ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад бодит хувь нэмрийг оруулдаг байгууллага юм.

Статистик

Дэлхийн 6 тивийн 118 оронд 86,055 ХЗХ 291 сая гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд гишүүдийн тоог эдийн засаг дахь идэвхтэй хүн амд харьцуулбал 9.55 хувийг эзэлдэг. Ази тивийн хувьд 24 орны 33,634 ХЗХ 64.8 сая гишүүнтэй бөгөөд гишүүдийн тоог эдийн засаг дахь идэвхтэй хүн амд харьцуулбал 5.24 хувь, Америк тивд 49.4 хувь, Европ тивд 10.5 хувь, Австрали тивд 4.65 хувь, Африк тивд 13.4 хувь гэсэн үзүүлэлтүүдтэй байгаа бол Өмнөд Солонгос улсын хувьд 16.9 хувь байна.

Монгол Улсад 2020 оны байдлаар 249 ХЗХ тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа бөгөөд нийт гишүүдийн тоо 72.6 мянгад хүрээд байгаа нь эдийн засаг дахь идэвхтэй хүн амын 5.5 хувийг эзэлж байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг авч үзвэл Америк улс 7.39 хувь, Канад улс 19.6 хувь, Тайланд улс 17.3 хувь, Кени улс 10.5 хувь, Өмнөд Солонгос улс 5.3 хувь гэсэн үзүүлэлттэй бол Монгол Улсын хувьд 0.6–0.7 хувийг, банкны зах зээлийн нийт хөрөнгө, зээл, хадгаламжийн 1 орчим хувийг тус тус эзэлдэг.

Дэлхийн 118 оронд ХЗХ-ны зах зээл үүсэж, тодорхой хөгжлийн түвшинд хүрээд байгаа боловч хөгжлийн зам дардан байгаагүй бөгөөд аль ч цаг үед болж байсан санхүүгийн хямралын үед ХЗХ-д зах зээл тодорхой эрсдэлийг үүрч, даван туулж байсныг түүх нотолдог. Жишээлбэл: Өмнөд Солонгосын хувьд ХЗХ-дын сургамж авч үлдсэн түүхүүдээс хамгийн анхны ба том нь 1997 оны санхүүгийн хямрал байсан. Тус хямралын үед маш олон ХЗХ-д дампуурлын ирмэгт очиж байсан бөгөөд Олон улсын валютын сан (IMF)-ийн санал болгосны дагуу бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөө боловсруулан ажилласнаар эдийн засаг сэргэж байсан байна. Энэ үед дампуурсан компанийн бондод хөрөнгө оруулсан маш олон ХЗХ-д

төлбөрийн чадваргүй болж эхэлсэн. Тухайн үед хүндрэл тохиолдсон буюу нийт хөрөнгийг 2 дахин үржүүлснээс ч их хэмжээний зээлийн эргэн төлөлт хийгдээгүй 239 ХЗХ байсан бөгөөд Солонгосын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо (NACUFOK) нь ХЗХ дампуурахад гишүүдийн хадгаламжийг хамгаалах зорилгоор 1984 онд бие даан байгуулсан “Аюулгүй байдлын сан”-тай байв. Аюулгүй байдлын сангийн тогтолцоо нь ХЗХ дампуурсан тохиолдолд хадгаламжийг гишүүдийн зээлийн үлдэгдэлтэй харьцуулан буцааж төлөхөд ашиглагддаг. Гэсэн хэдий ч 1997 оны санхүүгийн хямралын үеэр асуудалтай ХЗХ-дын тоо нэмэгдэж “Аюулгүй байдлын сан”-д маш их ачаа үүрүүлж, төлөх хадгаламжийн хэмжээ нь сангийн төлбөрийн

чадвараас давж, зах зээлийн тогтолцоонд иргэд итгэл алдах аюулд ороод байсан үе. Солонгос улсын Засгийн газраас ХЗХ-дын гишүүдийн хадгаламжийг хамгаалах хөтөлбөрийг сайжруулан хэрэгжүүлэхийг Хадгаламжийн даатгалын корпораци (KDIC)-д даалгасан байна. Хадгаламж хамгаалах хөтөлбөр болон ХЗХ-дын бүтцийн өөрчлөлтийн үр дүнд ХЗХ-дын систем тогтворжиж эхэлжээ. 1988 оны 4 дүгээр сараас 2003 оны 12 дугаар сар хүртэл KDIC нь 327 ХЗХ-ны бүтцийн өөрчлөлтөд зориулж төсвийн хөрөнгөөс 4.3 сая ам.доллар зарцуулсан байдаг бөгөөд бүтцийн өөрчлөлт хийсний дараа Солонгосын олон ХЗХ-д дампуурлаас аврагдсан боловч ихээхэн

хэмжээний хохирол амссан түүхтэй.

1970 онд Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (WOCCU) байгуулагдан зах зээлийн хөгжилд бодит хувь нэмрийг оруулсаар байна. Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбооноос ХЗХ-ны санхүүгийн бусад байгууллагуудаас ялгаатай өвөрмөц талуудыг бий болгодог суурь (4 бүлэг 44) зарчмыг дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт ХЗХ-дын 160 гаруй жилийн туршлагад тулгуурлан тодорхойлон гаргасан байдаг бөгөөд уг зарчмын хүрээнд ХЗХ-д үйл ажиллагаа явуулж, хамтын удирдлага, хяналтыг хэрэгжүүлдэг нь бусад санхүүгийн байгууллагаас ялгарах нэг онцлог болдог.

ХЗХ-ны зарчим	Үйл ажиллагааны зарчим	<ul style="list-style-type: none"> – Ардчилсан удирдлага, хамтын хяналт – Нээлттэй сайн дурын гишүүнчлэл – Гишүүдийг ялгаварлан гадуурхахгүй байх – Гишүүдэд санхүүгийн хүртээмжийг жигд хүргэх – Санхүүгийн тогтвортой байдлыг хангах – Гишүүдэд өгөөжтэй үйлчилгээ үзүүлэх – Гишүүдийг байнгын мэдээлэл, мэдлэгээр хангах – Хоршоодын хамтын ажиллагааг өрнүүлэх – Нийгмийн хариуцлага
	Гишүүдийн хамгаалалтын зарчим	<ul style="list-style-type: none"> – Хүү, шимтгэл, хураамжийн тухай мэдээллийн ил тод байдал – Мэдээллийн тогтмол байдлыг хангах – Үнэ зөв, ойлгомжтой мэдээллийг гишүүдэд хүргэх – Зээлийн шударга үйл ажиллагаа – Өр төлбөр цуглуулах цэгцтэй үйл ажиллагаа – Гишүүний мэдээллийн нууцлалыг хадгалах – Хоршоо нь дотооддоо шүүхэд хамааралгүй маргааныг шийдвэрлэх – Ухаалаг хэрэглээ, хэмнэлтийн талаар зөвлөгөө өгөх – Хоршооны өөрчлөлтийг шударгаар зохион байгуулах
	Аюулгүй болон тогтвортой байдлын зарчим	<ul style="list-style-type: none"> – Зээлийн хугацаа хэтрэлийг хянах – Зээлийн эрсдэлийн сан байгуулах – Өөрийн хөрөнгийн зохистой байдал – Орлого авчирдаггүй хөрөнгийн зохистой байдал – Боломжит үнийг тогтоох – Үйл ажиллагааны зардлын зохистой хэмжээ – Хөрвөх чадварын зохистой байдал – Төвлөрлийг сааруулах – Санхүүгийн бус үйл ажиллагааг хязгаарлах
	Засаглалын зарчим	<ul style="list-style-type: none"> – Үйл ажиллагааны ил тод байдал – Хууль тогтоомжийг дагаж мөрдөх – Бусад байгууллагатай хамтран ажиллах – Оновчтой бүтэц – Үйл ажиллагааны тасралтгүй байдал – Сонгуульд удирдлагын тэнцвэртэй сонголт – Хариуцлага – Гишүүд болон сонгуульд, гүйцэтгэх албаны ёс зүй – Удирдлагын үр чадвар – Сонгуульд удирдлагын үүргээ ухамсарласан байдал

ХЗХ-ны бусад байгууллагаас ялгагдах онцлог нь гишүүд оруулсан хувь хөрөнгөөс үл хамаарч аливаа шийдвэрт тэгш эрхтэй оролцож, үйлчилгээг ялгаварлалгүй хүртэх боломжтой байдаг оршино. Мөн тухайн байгууллага нь заавал гадны эх үүсвэр тусламж татахгүйгээр гишүүдээсээ

санхүүгийн нөөцөө бүрдүүлж, дотооддоо үндэсний баялгийг бүтээдэг онцлогтой. Иймд төрөөс ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, бичил санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ХЗХ-г дэмжиж ажиллах нь зүйтэй байдаг.

Туршлага

Олон улсад ХЗХ-г ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, орон нутгийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмрээ оруулдаг бичил санхүүгийн салбар гэдгийг хүлээн зөвшөөрч аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх, иргэдээ хуримтлалтай болохыг дэмжих, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд татвар ногдуулах хадгаламжийн доод хэмжээг бодит нөхцөл байдалтай уялдуулан тогтоох, ажлын байрыг түрээсгүйгээр эзэмшүүлж дэмжих, нийгмийн чиглэлийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зэрэг туршлагауд байна. Жишээлбэл, АНУ-д ХЗХ-г холбооны нөөцийн болон мужийн орлогын албан татвараас чөлөөлж, харин гишүүний оруулсан хувь хөрөнгөнд хуваарилсан ногдол хувь болон гишүүний хадгаламжийн хүүгийн орлогод хувь хүний орлогын албан татвар тооцон авах зарчим үйлчилж байна. Өмнөд Солонгос улс бага болон дунд орлоготой иргэдийн хуримтлалыг нэмэгдүүлэх зорилгоор ХЗХ-ны гишүүдийн 20 сая хүртэл воны хадгаламжийг хүүгийн орлогын татвараас чөлөөлдөг байсныг 2009 онд 30 сая хүртэл вон болгон нэмж хадгаламжийн болон салбарын нийт хөрөнгийн хэмжээг өсгөжээ. Мөн улс орны засгийн газар болон олон улсын хөгжлийн байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрөөс дурдвал Колумби улсад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий төслийг 2016–2019 онд хэрэгжүүлсэн бөгөөд төслийн үр дүнд 31 ХЗХ-доор дамжуулан 35 санхүүгийн шинэ бүтээгдэхүүн гаргаж, нийт иргэдийн 70 хувьд хүрч ажилласан байна. Мөн Америкийн олон улсын хөгжлийн агентлагаас 2017–2023 он хүртэл хэрэгжүүлж буй төслүүдийн хүрээнд цахим үйлчилгээгээр дамжуулж алслагдсан орон нутгийн иргэдэд санхүүгийн хүртээмжийг хүргэх, бизнес эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, зарим бүс нутгийн оршин суугчдыг орон байраар хангах зэрэг зорилт тавьж ажиллан тодорхой үр дүнгүүд гарсаар байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ГИШҮҮД СЗХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



УИХ-ын гишүүн Эдийн засгийн байнгын хорооны дарга Ж.Ганбаатар болон УИХ-ын гишүүн Х.Булгантуяа, Т.Доржханд, Х.Ганхуяг, М.Оюунчимэг нар байнгын хорооны гишүүд Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны үйл ажиллагаа, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, бодлого, зохицуулалт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, шийдвэрлүүлэх асуудлын талаар танилцлаа.

СЗХ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, харилцагч, үйлчлүүлэгчдийнхээ эрх ашгийг хамгаалах, хяналт шалгалт хийх, бодлого зохицуулалтын орчныг бүрдүүлэх чиг үүрэгтэй төрийн байгууллага юм. Хэдийгээр цар тахлын нөхцөл байдлын үед санхүүгийн зах зээл эрсдэлтэй, амаргүй нөхцөл байдал тулгарсан ч УИХ-аас баталсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх”, “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлээд байгаа талаар танилцууллаа.

Тухайлбал, хөрөнгийн зах зээлд төлбөр тооцооны Т+2 системийг нэвтрүүлснээр дотоод болон гадаадын бирж хооронд үнэт цаас хөрвөх боломжтой боллоо. Олон жил яригдсан биржийн бус зах зээлийн зохицуулалтыг бий болгож, санхүүжилт босгох таатай нөхцөлийг ийнхүү бүрдүүлснээр зах зээлийн үнэлгээ анх удаа 3.0 их наяд төгрөгт хүрсэн. Мөн олон нийтэд нээлттэй арилжаалах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг энэ онд анх удаа эхлүүлсэн. Ингэснээр хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй “Эрдэнэт Ресурс Деволпмент Корпорэйшн” ХК-ийн тодорхой хувьцааг Канадын Хөрөнгийн бирж рүү амжилттай хөрвүүлж хөрөнгийн зах зээлийн хөгжилд шинэ хуудсыг эхлүүлээд байна. Түүнчлэн Засгийн газраас хэрэгжүүлж буй “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэж санхүүгийн хэрэгсэл болголоо.



даатгалын компаниудын банкны харилцах хадгаламжид байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 10 хувиар бууруулж компанийн өрийн хэрэгсэлд, Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 10 хувиар нэмэгдүүлснээр даатгалын компаниудын олон талт хөрөнгө оруулалтад хөрөнгө байршуулах боломж бий болсон. Нийгмийн хариуцлагын хүрээнд даатгалын компаниуд ч “КОВИД-19” цар тахлын эрсдэлээс сэргийлсэн 4 шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээд байна.

Цаашилбал, банк бус санхүүгийн байгууллагуудын 272.7 мянган зээлдэгчийн 289.5 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, үндсэн төлбөр болон хүүг төлөх хугацааг сунгасан. Зээлийн батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэх зохицуулалтыг хийгээд байгааг энэ үеэр танилцуулсан юм.

Эцэст нь, банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу ойрын хугацаанд холбогдох ажлуудыг эхлүүлэхээр бэлтгэл ажлаа хийж байгаа талаар мэдээлэл өглөө.

Үүний дараа Эдийн засгийн байнгын хорооны дарга Ж.Ганбаатар хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээл рүү татахын тулд юуны түрүүнд хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчныг сайжруулж хуулийн этгээдийн олон сонголтод хэлбэрийг бий болгох, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд томоохон нөлөө үзүүлж чадах зээлжих зэрэглэл өндөртэй олон улсын томоохон санхүүгийн байгууллагуудыг зах зээлд татан оролцуулж хөрөнгө оруулахад дэмжлэг үзүүлэх чиглэлд анхаарч ажиллахыг зөвлөв.

Мөн тэрбээр салбарын хууль, эрх зүйн өөрчлөлтийг цаашид гүнзгийрүүлэх, шаардлагатай хуулиудыг хугацаа алдалгүй батлан гаргах, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийг хурдацтай хөгжүүлэх хөгжлийн оновчтой бодлого явуулах чиглэлээр Байнгын хороо хамтран ажиллахад эзлэн гэдгийг онцлоод УИХ-д өргөн баригдсан Хувийн тэтгэврийн тухай хууль батлагдвал засаглал, мэдээлэл тайлагнал, санхүүгийн чадавч сайтай компани шинээр хөрөнгийн зах зээлд гарах, урт хугацааны мэргэжлийн хөрөнгө оруулагч нэмэгдэх зэрэг томоохон дэвшил гарах учраас СЗХ энэ тал дээр санаачилгатай ажиллах чиглэл өгсөн юм.

СЗХ-НЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНКНЫ СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

СЗХ-ны дарга Д. Баярсайхан Монгол дахь Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD)-ны шинээр томилогдсон суурин төлөөлөгч Ханнес Такачийг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын үеэр хоёр тал одоо хэрэгжиж буй зарим төслийн хэрэгжилт, үр дүнгийн талаар санал бодлоо солилцлоо. Тухайлбал, “Монгол Улсын банк бус санхүүгийн байгууллагуудын эрх зүйн орчныг дэмжих төсөл”-ийн хүрээнд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан бөгөөд олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах чиглэлд хамтарч ажиллах болон “Тогтвортой хөгжлийг дэмжих Ногоон хөрөнгийн зах зээлийг урамшуулах бодлогын загвар ба зөвлөмжийн тухай” төслийн талаар хэрэгжилтийн талаар ярилцлаа. Суурин төлөөлөгч Ханнес Такач энэ үеэр банкны салбарын шинэчлэлийн



хүрээнд буюу банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, урт хугацаанд хөрөнгө оруулагчдын сонирхлыг нэмэгдүүлэх чиглэлд санал солилцлоо. Мөн виртуал хөрөнгийн үйлчилгээ, криптовалютай холбоотой эрсдэлийн талаар буюу эрсдэлийг бууруулах чиглэлд хамтран ажиллах талаар хоёр тал санал нэгдэв.

СЗХ-ны дарга Д.Баярсайхан Европын сэргээн босголт, хөгжлийн банкны техник туслалцааны хүрээнд СЗХ хэд хэдэн төслийг амжилттай хэрэгжүүлж, төслийн үр дүн санхүүгийн салбарын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсанд талархлаа илэрхийллээ. Тухайлбал, 2018–2020 онд хэрэгжсэн “Монгол Улсын мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх стратеги” техник хамтын ажиллагааны хүрээнд үнэт цаасны төлбөр тооцооны төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчим, Т+2 горимыг амжилттай нэвтрүүлснээр хөрөнгийн зах зээлд оролцогчдын арилжааны шимтгэл, зардал буурч, зах зээлийн хөрвөх чадвар сайжирч, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид үнэт цаасны арилжаанд оролцох таатай нөхцөл бүрдсэн гэдгийг онцолсон.

ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ОНЛАЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

СЗХ, Азийн хөгжлийн банкт хамтран “Бичил санхүүгийн зах зээлийг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх” төслийг 2018 оноос хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд банк бус санхүүгийн байгууллагуудад эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бөгөөд энэ хүрээнд Азийн хөгжлийн банкны төслийн зөвлөхүүд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрхэн явуулах аргачлалыг танилцуулсан онлайн сургалт зохион байгууллаа.

Энэ үеэр эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зарчмуудын талаар болон банк бус санхүүгийн байгууллагуудын эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын үнэлгээний талаар танилцуулсан юм. Мөн СЗХ-ноос хэрэгжүүлж буй эрсдэлд суурилсан хяналт шалгалтын одоогийн байдлын талаар мэдээлэл өглөө.

Сургалтад СЗХ-ны Банк бус санхүүгийн байгууллагын газар, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын холбогдох хянан шалгагчид болон Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны төлөөлөл оролцсон юм.

Дашрамд сонирхуулахад, төслийн хүрээнд СЗХ-ноос банк бус санхүүгийн салбарт финтек бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхэлж буй байгууллагуудад зээлийн багцад финтекээр олгосон зээл болон цахим зээлийн эргэн төлөлтийн хувь, хамтран ажилладаг байгууллагууд, финтек бүтээгдэхүүний нарийвчилсан мэдээлэл,

үйлчлүүлэгч, харилцагчдад тавигддаг шалгуур үзүүлэлт хэр байгаа талаар судалгаа хийсэн. Судалгааны дүн удахгүй гарна.

MOODY'S АГЕНТЛАГ МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ТӨЛӨВИЙГ “ТОГТВОРТОЙ” БОЛГОЖ АХИУЛЛАА



Зээлжих зэрэглэл тогтоогч “Мүүдиз” агентлаг энэ сарын 16-ны өдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “В3” хэвээр хадгалж, төлөвийг “тогтвортой” болгож ахиулсан байна. “КОВИД-19” цар тахлын сөрөг нөлөөллөөр буураад байсан Монгол Улсын эдийн засгийн төлөв байдлыг дараах үндэслэлээр тогтворжиж эхэлсэн гэж тус агентлагийн шинжээчид дүгнэсэн байна.

Тодруулбал, Засгийн газраас 2020 онд авч хэрэгжүүлсэн цар тахлын эсрэг цогц арга хэмжээг хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр болон улсын төсвөөс хамтран санхүүжүүлсэн нь Засгийн газрын зээллэгийн шаардлагыг бууруулсан;

Монгол Улсын экспортын хамгийн том зах зээл болох БНХАУ-ын эдийн засаг сэргэсэнээр уул уурхайн салбарын экспорт сайжирсан. Ялангуяа нүүрсний экспорт 2020 оны II хагаст сэргэж, алт, зэсийн экспорт өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна;

Өнгөрсөн оны 9 дүгээр сард авч хэрэгжүүлсэн өрийн дахин санхүүжилтийн арга хэмжээ нь 2021 оны эргэн төлөгдөх өрийн дарамтыг бууруулсан. Түүнчлэн 2022–2024 онд эргэн төлөгдөх нийт өр төлбөр ижил түвшний зээлжих зэрэглэлтэй улсуудтай харьцуулахад тийм ч өндөр биш байна;

Эргэн төлөх төлбөрөөс гадна төсвийн гүйцэтгэл сайжирсан нь зээлийн нийт эрэлт, хэрэгцээг багасгахад дэмжлэг болж байна. Төсвийн алдагдлыг 2021 онд бууруулж, ДНБ-ий өсөлтийг дэмжих гол хүчин зүйл нь уул уурхайн салбарын орлогыг нэмэгдүүлэх болно; Гадаад валютын албан нөөц 2021 онд 4.6 тэрбум ам.долларт хүрнэ гэж тооцоолсон байна.

“ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БА ЯПОН УЛСЫН ТУРШЛАГА” СУРГАЛТ БОЛЛОО

Монгол Улсад виртуал хөрөнгөтэй, холбоотой хууль, эрх зүйн тогтолцоог бий болгох ажлын хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас “Виртуал хөрөнгийн үйлчилгээ ба Япон Улсын туршлага” сэдэвт сургалтыг энэ сарын 09-ны өдөр зохион байгууллаа. Дэлхийн банк, Япон Улсын Санхүүгийн үйлчилгээний газартай хамтран явуулсан энэ удаагийн сургалтад СЗХ, Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба болон хууль хяналтын байгууллагуудын холбогдох албан хаагчид хамрагдсан юм.

Япон Улсын виртуал хөрөнгийн үйлчилгээний салбар нь бусад

улс орнуудтай харьцуулахад 2014 оноос хойш эрчимтэйгээр хөгжиж эхэлсэн. Одоогийн байдлаар 3.5 сая зах зээлийн идэвхтэй оролцогчидтой томоохон салбар бөгөөд тус улсын Санхүүгийн үйлчилгээний газар зохицуулалт тавьж, хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг юм. Тус байгууллагаас сургалтын үеэр сайн туршлага, эрх зүйн орчин, хяналт шалгалтыг хэрхэн хэрэгжүүлэх аргачлал, олон улсын шаардлагуудын талаар нээлттэй хэлэлцэж мэдээ, мэдээлэл өглөө.

Сургалтад оролцогчид олон улсын тэргүүний туршлагаас суралцахын зэрэгцээ Дэлхийн банкны мэргэжилтнүүдтэй цаг үеийн асуудлаар буюу виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний талаар санал солилцож, туршлага судалсан сургалт боллоо.

ДААТГАГЧ БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД ШИНЭЧЛЭГДЛЭЭ

УИХ, Засгийн газраас баталсан бодлого, стратегийн баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээ, Олон улсын даатгалын хянан шалгагчдын холбооноос боловсруулсан Даатгалын тулгуур зарчим (ICP), зөвлөмжид тулгуурлаж бусад орны зохицуулалтын орчин, туршлага мөн салбарт тулгамдаж буй асуудлыг судалж, зарчимд суурилсан тогтолцоог бий болгох зорилгоор СЗХ-ны 2021 оны 25 дугаар тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Тодруулбал, дүрмийн нэгдүгээр хавсралт “даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”, арван гуравдугаар хавсралт “даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ыг шинэчлэн, арван наймдугаар хавсралт “тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ыг нэмж баталсан юм.

Тухайлбал, тусгай зөвшөөрөл хүссэн иргэд, хуулийн этгээд болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд илүү ойлгомжтой, хэрэглэхэд хялбар дөхөм болгох, бүртгэл, зөвшөөрлийн үйл ажиллагааг олон улсын стандарт, цаг үеийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож цахимжуулахтай холбоотой зохицуулалтыг тусгаж өгсөн. Мөн санхүүгийн салбарын өрсөлдөөн болон хүртээмжийг дэмжих, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор даатгалын бүтээгдэхүүнийг зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зах зээлд борлуулдаг зохицуулалтыг (prior approval) өөрчилж зарчимд суурилсан зохицуулалтыг (principle based) оруулсан.

Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг сайжруулах зорилгоор даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь үйлчлүүлэгчтэй даатгалын гэрээг байгуулахаас өмнө болон байгуулсны дараа шаардагдах мэдээллүүдийг үйлчлүүлэгчид өгөх, авахтай холбогдох шаардлагыг ч бий болгосон. Түүнчлэн давхар даатгалын төлөвлөгөөг боловсруулахад даатгагчийн эрсдэлийн удирдлагын нэгж, ТУЗ-ийн хүлээх үүрэг, хариуцлага, давхар даатгалын үйл ажиллагааны улмаас даатгагчид учирч болзошгүй эрсдэл болон найдвартай хэвийн үйл ажиллагаа бүхий давхар даатгагчийг сонгох шалгуур үзүүлэлт зэргийг нарийвчлан тусгаж, даатгагчийн давхар даатгалын үйл ажиллагааны удирдлага, хяналт, хэрэгжилт нь үр дүнтэй, зохистой явагдах нөхцөлийг бүрдүүлээ.

Холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг ийнхүү оруулснаар хариуцлагатай, мэргэшсэн боловсон хүчинтэй, технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээтэй мөн ёс зүйтэй даатгалын салбар бүрэлдэх хөшүүрэг болох юм.

Захиргааны ерөнхий хуулийн дагуу дээрх эрх зүйн актууд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Үүнтэй холбогдуулж СЗХ-ноос энэ сарын 02-ны өдөр Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын банкны холбоо болон тэдгээрийн гишүүн байгууллагуудын төлөөлөлтэй цахим уулзалт хийж, нэмэлт, өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл өгч, хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах талаар зөвлөгөө, чиглэл өглөө.

САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС, МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ НАРЫН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ ГАРЛАА



СЗХ-ны зохицуулалтын хоёр салбар болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нарын 2020 оны жилийн статистик мэдээллийг агуулсан “2020 оны жилийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга” гарлаа.

Танилцуулгад хоёр салбарын өнөөгийн байдал, тусгай зөвшөөрөл олголт, статистик үзүүлэлт, борлуулалтын тойм, санхүүгийн тайлангийн үзүүлэлт, хяналт шалгалт, эрсдэлийн үнэлгээ зэрэг мэдээлэл багтсан.

Тухайлбал, СЗХ-ноос өнгөрсөн онд 167 хуулийн этгээдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 30 хуулийн этгээд, 399 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Харин 2 хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, нэр бүхий нэг хуулийн этгээдэд салбар нээн ажиллуулахыг зөвшөөрсөн. Мөн СЗХ-нд бүртгэлтэй 167 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь 188 брокер, 1,171 агенттайгаар үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн байна.

“СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ЖУРАМ” БАТЛАГДЛАА



Санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг дотоодын санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх, сэндбокс зохицуулалтын орчинг бүрдүүлэх зорилгоор СЗХ “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг боловсруулсан. Журамд СЗХ, Монголбанкны зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд тодорхой цаг хугацаанд турших боломж олгох, оролцогчдод тавигдах шаардлагыг тодорхойлох, холбогдох харилцааг зохицуулахаар тусгасан. Журмыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит хурлаар хэлэлцүүлээд зөвлөлийн гишүүн байгууллагууд буюу Монголбанкны ерөнхийлөгч, СЗХ-ны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирлын хамтарсан 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А-63/64/32/А/27 тушаалаар баталлаа.

Сэндбоксыг хэрэгжүүлснээр зохицуулагч байгууллагууд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний бодит хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, түүний эрх зүйн орчинг бүрдүүлэх нөхцөл бий болно.

Харин зах зээлд оролцогчдод хууль эрх зүйн зохицуулалтад нийцүүлсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, турших боломжийг нээж өгдөг тул финтекийн хөгжлөөр тэргүүлж буй улс орнууд сэндбокс орчныг зохицуулалтын оновчтой арга хэрэгсэл гэж үздэг. Сонирхуулахад, 2016 оноос зах зээлд нэвтэрсэн зохицуулалтын энэхүү арга хэрэгслийг дэлхийн 50 орчим улс идэвхтэй судалж, хэрэгжүүлж байна.

“МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР” БАТЛАГДЛАА

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь аж ахуй нэгж, байгууллагуудын бүтээмжийг дээшлүүлэх, орон нутаг, алслагдсан бүс нутгуудад амьдарч буй иргэдийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, эдийн засгийн оролцоог сайжруулах бодлогын чухал хэрэгсэл юм. Үүний тулд шинэ технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, түүнийг таниулах, санхүүгийн олон дэд салбарт (жишээ нь банк, бичил санхүү, даатгал гэх мэт), мэдээлэл харилцаа холбооны технологи, өгөгдлийн дэд бүтцийг хамарсан бодлогын өргөн хүрээтэй зорилтыг дэвшүүлж, эрэлт ба нийлүүлэлтийн талыг хамтад нь авч үзэх шаардлага тулгарч байна.

Статистик мэдээллээс харахад манай улсын санхүүгийн үйлчилгээний хүртээмж хөгжлийн ижил түвшинд буй улс оронтой харьцуулахад өндөр гарсан нь арилжааны банканд данстай иргэдийн тоогоор хэмжиж тодорхойлсонтой холбоотой. Энэ нь манай иргэд болон аж ахуйн нэгж банкнаас бусад санхүүгийн байгууллагаас хүртэж буй бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж сул гэдгийг илтгэж байна.

Иймд СЗХ-ноос эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”-ийг боловсруулсан. Улмаар хөтөлбөрийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит хурлаар хэлэлцүүлээд зөвлөлийн гишүүн байгууллагууд буюу Монголбанкны ерөнхийлөгч, СЗХ-ны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирлын хамтарсан 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А-62/63/31/А/26 дугаар тушаалаар батлагдлаа.

Санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр хэрэгжсэнээр хууль эрх зүйн орчин боловсронгуй болж дэвшилтэд технологид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтэрнэ. Мөн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл нэмэгдэж, үйлчилгээний зардал буурахын зэрэгцээ иргэдийн санхүүгийн боловсрол дээшилж, санхүүгийн үйлчилгээг хямд, хялбар, түргэн шуурхай хүргэх нөхцөл бүрдэх юм.



БАЙР СУУРЬ

ХЗХ-НЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГТ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ АЖИЛГҮЙДЭЛ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧУХАЛ НӨЛӨӨТЭЙ

СЗХ-ны Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга **Ц.Алтантуулай** ярилцлаа.

ХЗХ гэж 170 гаруй жилийн түүхтэй энэ байгууллагын олон улсын хандлага, статистик үзүүлэлтээр яриагаа эхэлье.

Таны хэлснээр санхүүгийн хоршоо буюу ХЗХ анх XIX зууны эхэнд Европ тивд үүссэнээс хойш 170 гаруй жил өнгөрч тодорхой хөгжлийн түвшинд хүрээд байна. Үүссэнээс хойш олон жил өнгөрсөн ч ХЗХ-ны анхны агуулга, зарчим өнөөдөр ч утгаа алдаагүй байдаг бөгөөд өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой санхүүгийн байгууллага. Гэхдээ Монголчуудын хувьд ХЗХ-г 2005–2006 оны үеийн дампуурлаар төсөөлөөд байдаг нь харамсалтай санагддаг. Одоогийн байдлаар дэлхийн 6 тивийн 118 оронд нийт 291 сая гишүүнтэйгээр 86 мянга гаруй ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (WOCCU) гэх байгууллага, түүний дор тивүүдийн холбоо, улс орнуудын үндэсний холбоо гэсэн бүтцээр үйл ажиллагаа явуулж, тусгай зөвшөөрөл бүхий ХЗХ-ын хөгжилд дэмжлэг үзүүлж хамтран хөгжсөөр ирсэн.

Монголчууд ХЗХ-ны хямралаар энэ байгууллагыг төсөөлдөг гэж та түрүүн хэллээ, энэ талаар тодруулбал?

Тиймээ. Хэдийгээр энэ зах зээл дэлхий нийтэд үүсэж хөгжөөд олон жил болж байгаа ч үе үеийн санхүүгийн хямралаар эрсдэлд өртөн тодорхой хохиролтойгоор даван туулах, зохицуулалтын дутагдлаас үүдсэн зохиомол гажуудал бий болох зэргээр унаж боссоор тодорхой шатанд ирсэн. Энэ үйл явдал Монгол Улсад төдийгүй ХЗХ өндөр хөгжсөн орнуудад ч тохиолдсон байдаг. Тухайлбал, Өмнөд Солонгос ХЗХ-ны зах зээлийн хөгжлөөрөө дэлхийд эхний 5 байранд ордог улс. 1997 онд болсон санхүүгийн хямралын үеэр маш олон хоршоод төлбөрийн чадваргүй болсон ч түүнээс өмнө байгуулсан “Аюулгүй байдлын сан”-тай байсан тул хохирлын тодорхой хэсгийг тухайн сангаас гаргаж,

мөн төрөөс тодорхой дэмжлэг үзүүлэх замаар хямралаас гарч байсан. Польш улсын хувьд 2008 онд болсон санхүүгийн хямралд ХЗХ-д өртөх үед зах зээлийн тусгайлсан хуульгүй байсан бол түүний дараа хууль эрхзүйн орчныг бүрдүүлж, хамгаалалтын сан, системийг бий болгон хөгжүүлсээр зах зээлийг тогтворжуулсан. Ийнхүү эдгээр хямрал, гажуудлыг даван туулах, хамгаалах зорилгоор хамгаалалтын механизмуудыг улс орнууд хэрэгжүүлсээр эдийн засагт тодорхой үүргийг гүйцэтгэсээр байна. Манай улсын хувьд ч мөн адил хямралын дараа зах зээлийн бие даасан хуультай болж, төрийн оролцоотойгоор даван туулсан түүхтэй.

Зохицуулалтын дутагдал гэснийг тодруулбал?

Өмнөх түүхээс ярьж л даа. СЗХ 2006 онд байгуулагдаж зохицуулалтдаа хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодыг хамааруулсан байдаг. 2006 оны 3 дугаар сараас эхлэн хоршоодод тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн. СЗХ байгуулагдахаас өмнөх үед улсын бүртгэлийн байгууллагад бүртгэлтэй ХЗХ-ны тоо 900-д хүрсэн байсан. Тусгай зөвшөөрөлгүй хоршоодыг хяналтаас гадуур үлдээхгүйн тулд УИХ-аас Хоршооны тухай хуулийн зарим заалтыг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталж, 2007 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор СЗХ-нд хандаж тусгай зөвшөөрөл авах хугацааг нийт хоршоодод олгосон. Заасан хугацаанд хүсэлтэй гаргаагүй 420 хоршоо шүүхийн шийдвэрээр татан буугдаж, бас өөрийн хүсэлтээр 200 хоршоо татан буугдсан байдаг. Ингэж явсаар 2006 оны эцэст 52 ХЗХ, 2007 оны байдлаар 179 ХЗХ үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны үйл ажиллагаанд тавих нөхцөл шаардлага, хяналтын тогтолцоог бий болгох, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

олгоход тавигдах шалгуур зэрэг холбогдох харилцааг зохицуулах шаардлага гарсан. Нөгөөтээгүүр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршооны онцлог, олон улсын чиг хандлага, туршлагыг харгалзан уг асуудлыг тусгайлан хуулиар зохицуулах нь зүйтэй болсон. УИХ-аас 2011 онд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг баталснаар манай улс ХЗХ-ны талаар бие даасан хуультай болсон бөгөөд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг боловсруулахдаа WOCCU-аас гаргасан загвар хууль болон олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжүүдэд тулгуурлан эрх зүйн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэхийг зорьсон. Мэдээж бусад улс орны нэгэн адилаар хямралын дараах асуудал гажуудлыг зохицуулах, хамгаалалтын механизмыг бий болгон хөгжүүлэхээр зорьсон байдаг. Тус хуулийг олон улсын туршлага, өөрийн орны нөхцөл байдалд тулгуурлан гаргасан учраас ХЗХ-ын дундын сан үүсгэн удирдаж зах зээлийг тогтворжуулах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэл бий болсон тохиолдолд гишүүдийн хадгаламжийн даатгалын системээр дамжуулан эрсдэлийг бууруулах, даван туулах арга хэмжээ авах зэргээр хамгаалалтын механизмуудыг үүсгэхээр тусгасан.

Тэгвэл ХЗХ-ны онцлогийн талаар яриагаа үргэлжлүүлэх үү?

ХЗХ нь гишүүддээ үйлчилдэг бөгөөд тэдний эдийн засгийн болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг, харилцан итгэлцэл дээр суурилсан, гишүүдийн хэн нь ч сонгуульт болон гүйцэтгэх удирдлагаар сонгогдох боломжтой ардчилсан удирдлага, хамтын хяналттай байгууллага гэдгийг маш сайн ойлгох хэрэгтэй. Тиймээс ХЗХ-ны гишүүн та бол эзэн нь гэдгээ ухамсарлаж, үйл ажиллагаандаа байнга идэвхтэй оролцох нь нэн чухал. ХЗХ нь Санхүүгийн байгууллага учраас гишүүдийнхээ эдийн засгийн хэрэгцээг хангахын төлөө ажиллах нь зүйн хэрэг ч нийгмийн хэрэгцээг хангах гэсэн

хос зорилготойгоороо онцлог. Үүгээр юуг хэлэх гээд байна вэ гэхээр урт хугацаанд 1 байгууллагын гишүүд байж эдийн засаг, нийгмийн хэрэгцээгээрээ нэгдэх тул үнэнч хэрэглэгч, итгэлтэй хамтрагч нар болж амьдрал ахуйгаа дээшлүүлнэ гэсэн үг.

Түүрэн дурдсан WOCUU гэж байгууллагаас хоршоодын олон жилийн түүх, туршлагад үндэслээд суурь зарчмуудыг тодорхойлсон байдаг бөгөөд дэлхийн улс орнуудын ХЗХ-д зохицуулалтдаа тусган мөрдлөг болгон ажилладаг. Энэхүү зарчмыг бүлэглэвэл дотоод, гадаад, хувь хүний гээд байгууллага дотооддоо ямар зарчим баримталж ажиллах уу, гадаад талдаа ямар зарчим баримтлах уу, гишүүнчлэлийн хүрээнд ажилладаг тул хувь хүний хувьд ямар зарчим баримтлах уу гэдгийг маш олон үзүүлэлтээр буюу 4 бүлэг 40 гаруй зарчмаар тодорхойлсон байдаг.

Онцлогийн талаар ярьж байгаа учраас ХЗХ-ны бүтэц, зохион байгуулалтын талаар товчхон дурдъя. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулиар зохицуулснаар ХЗХ-г тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хороо, гүйцэтгэх захирал, ажилтантай байхыг шаарддаг. ХЗХ-ны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байх бөгөөд хоршооны дүрмийг батлах, өөрчлөлт оруулах, үндсэн бүтцийн нэгжүүд болох тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, өөрийн хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагааны бодлого, журмыг батлах, үйл ажиллагааны төсвийг батлах, эргээд үйл ажиллагааны тайланг хэлэлцэх зэрэг бүрэн эрхтэй. Энэ бүрэн эрхээр дамжуулж гишүүн бүр ХЗХ-нд оруулсан хөрөнгийн хэмжээнээс үл хамаарч саналын нэг эрхтэйгээр хоршоотой холбоотой аливаа шийдвэр гаргахад оролцдоггоороо мөн бусад байгууллагаас онцлогтой.

ХЗХ эдийн засагт яг ямар үүргийг гүйцэтгэдэг вэ?

ХЗХ нь заавал гадны эх үүсвэр тусламж татахгүйгээр гишүүдээсээ санхүүгийн нөөцөө бүрдүүлж, дотооддоо үндэсний баялгийг бүтээдэг онцлогтой. Гишүүн бүрийн оруулсан хувь хөрөнгө, хадгаламжийг эх үүсвэр болгож үйл ажиллагаагаа явуулах бүрэн боломжтой байдгаараа бусад санхүүгийн байгууллагаас ялгаатай гэдгийг онцольё. Эдийн засагт гүйцэтгэх үүргийг хэд хэдэн үзүүлэлтээр хэмжээд байгаа юм. Тухайн улсын ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө нь дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д хэдэн хувийг эзэлж байгаа, гишүүдийн тоо нь эдийн засгийн идэвхтэй хүн амд хэдэн хувийг



эзэлж байгаа, мөн тухайн орон нутагт хэдэн хүнийг ажилтай байлгаж байна вэ, бичил санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж байгаа эсэх гэх мэтчилэн. Эдгээрээр дамжуулаад нийгэм дэх ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, бичил санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бодит хувь нэмрийг оруулдаг байгууллага бол ХЗХ байдаг учраас төрөөс энэхүү байгууллагаар дамжуулан тодорхой бодлогуудыг авч хэрэгжүүлэх нь үр дүнгээ өгдөг. Улс орнуудын тоон статистикаас ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн ДНБ-д эзлэх хувийг авч үзвэл Америк улс 7.4 хувь, Канад улс 19.6 хувь, Тайланд улс 17.3 хувь, Кени улс 10.5 хувь, Өмнөд Солонгос улс 5.3 хувь гэсэн үзүүлэлттэй байгаа бол Монгол Улсын хувьд 0.6–0.7 хувийг эзэлж байна. Харин гишүүдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулбал Ази тивийн хувьд 5.2 хувь, Америк тивд 49.4 хувь, Европ тивд 10.5 хувь, Австрали тивд 4.7 хувь, Африк тивд 13.4 хувь, Өмнөд Солонгос улсын хувьд 16.9 хувь, Монгол Улс 5.49 хувь буюу Ази тивийн дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна. Тус үзүүлэлтүүдээс харвал Америк тивд нийт ажиллах хүчний 50 орчим хувь нь өөрсдийн эзэмшлийн санхүүгийн хоршоогоор үйлчлүүлдэг болох нь харагдаж байна. Харин ДНБ-д зах зээлийн нийт хөрөнгийн эзлэх

хувь 5-аас дээш хувьтай байгааг харж болно.

Зах зээлд баримталж байгаа бодлогыг цөөн үгээр тодорхойлол?

СЗХ алсын хараагаа “Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.”, эрхэм зорилгоо “Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.” гэж тус тус тодорхойлсон. ХЗХ бол санхүүгийн зах зээлийн салшгүй хэсэг тул бусад зах зээлийн адил тогтвортой хөгжиж эдийн засагт хувь нэмрээ оруулах ёстой. Энэ үүднээс Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т ХЗХ-ны зах зээлийн хөгжлийн талаар тусгайлан зорилт дэвшүүлсэн. ХЗХ-ны өвөрмөц онцлогийг харгалзан орон нутагт илүүтэйгээр хөгжүүлэх, хамгаалалтын механизмуудыг бий болгох, мэргэжлийн санхүүгийн байгууллага болгон хөгжүүлэх бодлогын үр дүнд бичил санхүүгийн

хүртээмж, зах зээлд оролцогчдын сахилга бат сайжирч, эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь 2–3 дахин нэмэгдсэн байхаар тодорхойлоод холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Цар тахлын нөхцөл байдал ХЗХ–ны зах зээлд ямар нөлөө үзүүлж байна вэ? Цар тахлын нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дурдвал?

Зах зээлийн хувьд ХЗХ–ын нийт хөрөнгө, хадгаламж болон зээлийн үзүүлэлт 2015–2019 онуудад жилд дунджаар 23–28 хувийн өсөлттэй байсан бол 2020 оныг өмнөх онтой харьцуулахад нийт хөрөнгө 15.0 хувь, нийт хадгаламжийн хэмжээ 16.9 хувь, нийт зээл 6.9 хувиар тус тус өссөн байгаа. Зах зээл өсөлттэй мэт харагдаж байгаа ч өсөлт саарсан болохыг харж болно. Гэхдээ бусад санхүүгийн байгууллагатай харьцуулахад гишүүнчлэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг гэдгээрээ тодорхой давуу талууд харагдаж байна. Учир нь гишүүдийн хадгаламж болон оруулсан хувь хөрөнгө нь нийт эх үүсвэрийн 90 гаруй хувийг бүрдүүлдэг бөгөөд цар тахлын нөхцөл байдлын үед хадгаламж болон зээлийн хүүгээ бууруулах, ногдол ашгийг тараалгүй тэвчиж нөөцийн сангаа нэмэгдүүлэх гэх мэтчилэн ХЗХ–гоо тогтвортой ажиллуулах арга хэмжээг дотооддоо авч хэрэгжүүлж байгаа туршлага харагдаж байгаа нь гишүүнчлэлийн байгууллагыг нэг давуу талыг харуулж байна. Монгол Улс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн байдлын зэрэгт шилжсэнээс

эдийн засгийн идэвхжил саарч, иргэд, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэний улмаас санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалах зорилгоор СЗХ–ны дарга, Сангийн сайдын 2020 оны 122/58 дугаар хамтарсан тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”–д нэмэлт оруулж, өөрчлөлтийг 2020 оны 7 дугаар сарын 31–ний өдөр хүртэл хугацаанд мөрдүүлэхээр шийдвэрлэсэн. Тус өөрчлөлтөөр зээлдэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс цар тахлын нөлөөнөөс шалтгаалан зээлийн эргэн төлөлтөд хүндрэл үүссэн бол зээлийн ангиллыг бууруулах хугацааг шатлалтайгаар хойшлуулах зохицуулалтыг хийсэн. Цар тахлын нөхцөл байдал арилагүй учраас тогтоосон хугацааг 2021 оны 7 дугаар сарын 01–ний өдөр хүртэл сунгасан. СЗХ–ны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”–д 2020 оны 12 дугаар сарын 23–ны өдрийн тогтоолоор өөрчлөлт оруулсан. Уг нэмэлт өөрчлөлтөөр ХЗХ–ын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр зарим зохистой харьцааны тооцооллын суурийг өөрчилсөн. Мөн СЗХ–ны 2020 оны 12 дугаар сарын 23–ны өдрийн хуралдаанаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх

тусгай зөвшөөрөл, хадгаламж, зээлийн хоршооны салбар байгуулах болон санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн хүсэлтийг 2021 оны 7 дугаар сарын 01–ний өдрийг хүртэл хүлээж авахгүй байхаар шийдвэрлэж, тогтоосон хугацаанд гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах, тогтворжилтын сангийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг урт хугацаанд салбарын тогтвортой хөгжлийг хангах ажилд бэлтгэх, хадгаламж, зээлийн хоршоодын эрсдэлийг тогтоох чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухайд?

Дэлхий нийтээрээ санхүүгийн зах зээлд технологид суурилах урсгал эрчимтэй явж байна. Цаашлаад үйлчилгээ нь технологид суурилагаас гадна зохицуулалт, түүнчлэн хяналт шалгалтыг технологид суурилуулах хандлага ч мөн яригдаж эхлээд байна. Иймд зах зээлд технологид суурилсан бүтээгдэхүүн бий болгоход анхаарч байна. ХЗХ–ны зах зээлийг хамгаалах механизм болох тогтворжилтын сан, хадгаламжийн даатгалын системийг ажиллуулахад анхаарал хандуулж, ХЗХ–ыг чадавхжуулах, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, зах зээлийн тогтвортой байдлыг хангахад анхаарлаа хандуулж байна. Энэ хүрээнд ХЗХ–ны тухай хуулийг шинэчлэх ажил хамаарч байгаа бөгөөд холбогдох судалгааг хийгээд эхний хэлэлцүүлгүүдээ хийж байна.



ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

1. Зохицуулах харилцаа

СЗХ–ны 2020 оны 995 дугаар тогтоолоор баталсан “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам” нь биржийн бус зах зээлийн хамрах хүрээ, удирдлага зохион байгуулалт, хяналт, зах зээлд оролцогчид, арилжаа явагдах программ хангамжид тавигдах шаардлага, арилжааны төлбөр, өмчлөх эрхийн бүртгэл, төвлөрсөн хадгаламж, мэдээллийн ил тод байдал, СЗХ–ны эрх, үүргийг тодорхойлох, СЗХ–ноос хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан.

2. Удирдлага зохион байгуулалт

Журмаар үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудын төлөөллийг багтаасан “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ӨЗБ /МҮЦАЭХ/ нь биржийн бус зах зээлийг удирдан зохион байгуулах үүрэг хүлээж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор МҮЦАЭХ–ноос биржийн бус зах зээлийн нарийвчилсан харилцааг зохицуулсан журмуудыг боловсруулахаас гадна арилжааны цахим программ хангамжийн бэлэн байдлыг бүрэн хангаж, биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэл болон арилжааны үйл ажиллагааг явуулна.

3. Биржийн бус зах зээл дээр арилжаалагдах санхүүгийн хэрэгсэл:

Засгийн газрын өрийн хэрэгсэл болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1–т заасан дараах үнэт цаасыг нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд гарган биржийн бус зах зээл дээр арилжаалж болно:

- Хувьцаат компанийн хувьцаа /хаалттай/
- Компанийн хаалттай өрийн хэрэгсэл
- хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх
- хадгаламжийн бичиг
- хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
- үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчид санал болгож байгаа тодорхой тооны хувьцаа болон өрийн хэрэгслийг тодорхой хугацааны дотор тохиролцсон үнээр захиалах эрх /варрант/
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үүсмэл санхүүгийн хэрэгсэл;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу СЗХ–ноос үнэт цаас гэж тогтоосон бусад санхүүгийн хэрэгсэл

4. Биржийн бус зах зээлийн оролцогчид:

Үнэт цаасны брокерын, дилерийн, үнэт цаасны итгэмжлэн удирдах, андеррайтерийн, кастодианы, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдүүд биржийн бус зах зээл дээр өөрийн өмчлөлийн болон өмчлөгчөөс эрх олгосон журамд заасан санхүүгийн хэрэгслийг харилцан шууд худалдах, худалдан

авах гэрээ байгуулах үйл ажиллагаа явуулна.

Түүнчлэн журамд заасан шаардлага хангасан иргэн, хуулийн этгээд, хууль тогтоомжоор хориглоогүй бол Монгол Улсын Засгийн газар, түүний харьяа байгууллагууд, Төв банк /Монголбанк/, Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Засгийн газрын тусгай сан, Зээлийн батлан даалтын сан, бүх төрлийн даатгалын сан зэрэг нь үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр дамжуулан биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох боломжтой.

5. Гарах үр дүн

Биржийн бус зах зээлийн арилжааны эрх зүйн орчин бий болсноор дээр дурдсан санхүүгийн хэрэгслийг нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд гарган арилжаалах нэгдсэн тогтолцоотой болж, үнэт цаас гаргахад зарцуулдаг цаг хугацаа, зардлыг хэмнэхээс гадна мэдээллийн ил тод байдал хангагдан мэргэжлийн хөрөнгө оруулагчдын зүгээс хаалттай хүрээнд хөрвөх чадвар сайтай хоёрдогч зах зээл үүсгэх зэрэг чухал ач холбогдолтой.

Мөн нийтэд санал болгон гаргах үнэт цаасны шаардлага, шалгуурыг хангахад хүндрэлтэй байгаа аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарт биржийн бус зах зээлээс санхүүгийн хэрэгсэл гаргах замаар санхүүжилт босгох таатай нөхцөл бүрдэнэ.

Нөгөөтээгүүр, биржийн бус зах зээлд оролцогч хөрөнгө оруулагч нарт тодорхой шаардлага, шалгуур тавьснаар санхүү, хөрөнгө оруулалт, хөрөнгийн зах зээлийн талаар хангалттай мэдлэг, мэдээлэлгүй, мөн эрсдэл даах чадвар сул, жижиг хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалагдана.



ФИНТЕК БА РЕГТЕК

КРИПТОВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Технологийн дэвшлүүд ар араасаа гарч, зах зээлд шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэх нь санхүүгийн инноваци болон үр ашигтай байдлыг үүсгэж цаашлаад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ энэ нь гэмт хэрэгтэн, террористуудад мөнгө угаах эсвэл өөрсдийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх арга замуудыг бий болгож байдаг. Эдгээр технологийн дэвшилтэт шийдлүүдийн нэг нь виртуал хөрөнгийн нэг болох криптовалют юм.

Криптовалют нь үйл ажиллагааны, зах зээлийн, хөрвөх чадварын зэрэг эрсдэлүүдийг дагуулдаг учир хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахаас гадна санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах үүднээс улс орны зохицуулагч байгууллагууд зохицуулалтын арга хэмжээг авах шаардлагатай болсон.


Төв банк, санхүүгийн зохицуулагч байгууллагуудын зүгээс иргэд, олон нийтдээ криптовалютын үнийн хэлбэлзэл болон хууль бус үйл ажиллагаатай холбогдох эрсдэлийн талаар сэрэмжлүүлж, анхааруулах мэдэгдэл хийх нь хамгийн нийтлэг хэрэгжүүлж буй арга хэмжээ байна.

Криптовалют нь хэрэглэгчийг нэрээ нууцлан гүйлгээ хийх боломжийг олгодгоороо мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх /МУТС/ эрсдэл үүсгэж болзошгүйг харгалзан үзэж зарим улс, орнууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /МУТС/ тухай хууль, эрх зүйн актууддаа нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгах байдлаар криптовалютын үйл ажиллагааг зохицуулсан хэлбэртэй байна.


Олон улсын хууль эрх зүйн зохицуулалт

Улс орнуудын хөгжлийн түвшнээс хамаараад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь харилцан адилгүй байгаа ба хөгжлийн түвшин өсөх тусам хууль эрх зүйн орчинд өөрчлөлт хийх, тусгайлан хууль батлах зэргээр зохицуулах хандлага ажиглагдаж байна.

Зураг 1. Улс орнуудын криптовалютын зохицуулалт, хөгжлөөр



Зураг 2. Зохицуулагч байгууллагууд



Зохицуулалтын арга хэмжээ авсан улсуудын 43.2 хувь нь төв банкны, 37.5 хувь нь санхүүгийн зохицуулагч байгууллагын, 19.3 хувь нь хосолсон буюу бусад зохицуулалттай байна.


Улс орнууд криптовалютад хөрөнгө оруулах, ашиглахыг зөвшөөрөх гол шалтгаан нь криптовалют олборлох, борлуулахаас олсон орлогыг орлого, хөрөнгийн ашиг гэж үзэж татвар ногдуулахад оршсон. Гэхдээ криптовалютыг ямар зорилгоор ашиглаж байгаагаас шалтгаалан татварыг ерөнхийдөө 2 янзаар ногдуулах хандлага ажиглагдсан:

- Криптовалютыг арилжиж олсон орлогод татвар ногдуулах
- Криптовалютыг олборлох, худалдан авах, зарахтай холбоотой НӨАТ

Судалгаанд хамруулсан 102 улс орноос зөвхөн хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулсан 32 улс орны хувьд 21 нь криптовалютыг зохицуулах хүрээнд татварын тухай хуульд холбогдох өөрчлөлт хийсэн байна.

Эдгээр улсууд татварын хуулиараа криптовалют арилжиж олсон орлогод татвар ногдуулсан бол тэдгээрийн 23.8 хувь нь нэмээд НӨАТ-ыг ногдуулсан байна. Харин Криптовалют нь хууль ёсны төлбөрийн хэрэгсэл биш (Люксембург), олборлолт нь зөвхөн технологийн үйл ажиллагаа (Норвеги), эсвэл криптовалютын арилжаа нь бараа, үйлчилгээнд хамаарахгүй (Латви, Австри) гэсэн үндэслэлээр улс орнууд НӨАТ-ыг ногдуулаагүй байна.

Зураг 3. Татварын хуульд өөрчлөлт оруулсан байдал



Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага болох ФАТФ-аас 2018 онд Зөвлөмж 15-д өөрчлөлт оруулж виртуал хөрөнгийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд байлгах нь шаардлагатай гэж үзсэний үр дүнд улс орнууд виртуал хөрөнгө, криптовалютын үйл ажиллагааг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд тусгасан байна. Тухайлбал Коста Рика, Чех, Эстон, Хонг Конг, Латви, Люксембург, Сингапур.

Тэгвэл Австрали, Канад, Дани, Япон, Швейцар зэрэг улс орон Татварын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд хоёуланд зохицуулалт тусгасан байна.


Европын гишүүн орнуудын хувьд Европын Шүүхийн (ЕСЖ) 2015 оны шийдвэрээс шалтгаалан криптовалютын хөрөнгө оруулалтын ашигт Европын Холбооны гишүүн орнуудад нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулдаггүй.

Зохицуулалтын сэндроксыг ашиглах

Зарим улсуудын хувьд санхүүгийн салбарт гарч буй технологийн дэвшлүүдийг хөгжүүлэх, зохицуулалтыг сайжруулахаар нэвтрүүлсэн сэндрокс, инновацийн төвүүдээр дамжуулан криптовалютын зохицуулалтыг хөгжүүлж байна.

Судалсан 102 улсын 31 нь зохицуулалтын сэндроксыг нэвтрүүлсэн бөгөөд тэдгээрийн 20 нь криптовалютыг хууль эрх зүйн хүрээнд зохицуулах шийдлийг хийсэн байна.

Зураг 4. Сэндрокс хэрэгжүүлсэн улсууд, зохицуулалт хийсэн байдал



Арабын Нэгдсэн Эмират: Абу Дабигийн сэндроксын хүрээнд криптовалюттай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг оролцогчдод Кripto хөрөнгийн хуулийг туршиж, хэрэгжилтийг шалгасан.

Бахрейн: Бахрейн улсын төв банкны нэвтрүүлсэн зохицуулалтын сэндроксын орчинд “Crypto-asset module” буюу зөвхөн криптовалютын зохицуулалт, хөгжүүлэлтийг сайжруулах зорилготой хөтөлбөрийг явуулж байна. Нийт сэндроксод оролцогчдын 40 гаруй хувь нь зөвхөн крипто-хөрнгөтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг ба энэхүү хөтөлбөрийн үр дүнд Бахрейны төв банкнаас 2019 онд криптовалютын үйл ажиллагааны тухай хуулийг гаргасан байдаг.

Их Британи: Анх 2015 онд сэндроксыг эхлүүлснээс хойш нийт оролцогчдын 30 хувь нь DLT ашигладаг эсвэл криптовалюттай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг. Ингэснээр бодлого гаргагчид бизнес загвар болон зах зээлд үзүүлэх нөлөөллийн талаар илүү

ойлголттой болсон. Кripto-хөрөнгийн зөвлөмжийг 2019 онд гаргасан.

Литва: Литвийн төв банкны зохицуулалтын сэндрокс болох LBCChain нь зөвхөн криптовалютай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг компаниудад зориулсан бөгөөд ингэснээр криптовалютын талаар илүү ойлголттой болно гэж үзжээ

Швейцар: 2020 оны Дэлхийн инновацийн индексийн жагсаалтад тэргүүлсэн улс болох Швейцар улсын хувьд инновацийн төв, тэр дундаа блокчэйн төвийг Zug хотод байгуулсан бөгөөд тус төвөөр блокчэйнтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг нийт 800 гаруй компани хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэдэг байна (2020 оны 2 дугаар хагас). Инновацийн төвийг ашигласны үндсэнд үйлчилгээ үзүүлэгчид болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, хууль эрх зүйн орчинг



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Эхлэл 1-р нүүрт

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт Н.Нарантуяа

Тогтвортой санхүүжилтэд ямар шалгуур үзүүлэлт тавигдаж байгаа вэ? Та энэ зээлд хамрагдаж, санхүүжилтийн өртгөө бууруулах боломжтой юу?

Тогтвортой санхүүжилт нь хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр, урт хугацааны санхүүжилт олгодог давуу талтай. Арилжааны банкуудын хувьд тогтвортой санхүүжилтийн 8 зарчим, барилга, уул уурхай, хөдөө аж ахуй, боловсруулах болон нэхмэлийн салбар гэсэн 5 удирдамжид туссан үнэлгээний дагуу таны зээлийн хүсэлтийг үнэлдэг Монголын тогтвортой санхүүгийн холбооны цахим хуудас (<http://www.toc.mn/>)–нд хандан танилцах боломжтой.

Ногоон, тогтвортой зээлд 2020 онд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 13.2 хувьтай байгаа бол арилжааны банкны энгийн зээл 16.2 хувьтай байгаа нь уг төрлийн зээлийн өртөг 3 хувиар бага буйг илтгэнэ.

Тогтвортой санхүүжилт нь анх улс даяар байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг дэмжих шаардлагатайг 1960–аад оноос хөндөх болсноор томоохон хөрөнгө оруулагчид, олон улсын болон санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмд ээлтэй санхүүжилт олгож буй байдлыг үнэлэн хөрөнгө оруулалт хийж, санхүүжилт олгож, мөн тусгай сангууд бий болсон. Ингэснээр санхүүгийн байгууллагууд таатай нөхцөлөөр олон улсын санхүүгийн зах зээлээс санхүүжилтийн эх үүсвэр татахын тулд иргэд,



аж ахуй нэгжүүдэд зээл олгохдоо уг үнэлгээг ашигладаг болсон.

2015 онд НҮБ–аас “Тогтвортой хөгжлийн 30 зорилго”–ыг, үүний дараа 196 орон хамтран уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Парисын хэлэлцээрийг хамтран баталснаар дэлхийн бүх улс орнууд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн өсөлтийг тэгш, хүртээмжтэйгээр өсгөх үйлд нэгдсэн. Үүний үр дүнд манай улсад дараах ногоон, тогтвортой зээлийн сангууд санхүүжилт олгож байна:

- Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл (AHURP).
- Монголын ногоон санхүүгийн корпораци (MoHCaK) төсөл нь 2016 оноос хойш боловсруулагдаж, сайжруулсаар ирсэн бөгөөд 2019 онд Уур амьсгалын ногоон сан (УАНС)–аас Төсөл бэлтгэх хөтөлбөрийг авсан. Уг төсөл нь Монгол Улсад үндэсний хэмжээний ногоон санхүүгийн системийг бий болгож, Монгол Улсын ногоон хөгжлийн бодлого, Парисын хэлэлцээрт тусгасан үндэсний зорилтот хувь нэмрийг хэрэгжүүлэн, тогтвортой, ногоон ирээдүйг бий болгоход санхүүжилтээр дамжуулан дэмжлэг үзүүлэх алсын хараатай.
- “Монгол Улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих” , “Барилгын эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх” төслүүд нь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)–ээс хэрэгжүүлж буй бөгөөд нь Эрчим хүчний үр ашгийн шалгуур үзүүлэлт болон үүнтэй холбоотой сургалтын концепц боловсруулах ажил юм. Эрчим хүчний хэмнэлттэй байшин ба түүний санхүүжилтийн шийдэл хэрэгжүүлэхээр 60 орчим эрчим хүчний хэмнэлттэй байшинг банкны зээлээр дамжуулан иргэдэд олгох туршилтыг энэхүү GIZ төслийн хүрээнд нийт 240,000 еврогийн татаасыг иргэдэд урьдчилгаа төлбөрийн 20 хувь хүртэлх буцалтгүй тусламж хэлбэрээр олгох юм.
- Нэхмэлийн салбарын жижиг, дунд үйлдвэрүүдэд очих ногоон, тогтвортой санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой “Монголын нэхмэлийн салбарын байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг” төсөл нь 2018 оноос эхэлсэн бөгөөд 4 жилийн хугацаатай хэрэгжинэ.
- Уур амьсгалын ногоон сан (Green Climate Fund) нь НҮБ/УАӨСК–ын Талуудын 16 дугаар бага хурлын шийдвэрээр 2010 онд байгуулагдсан бөгөөд хөгжиж буй орнуудын хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтөд хариу өгөх чадварыг дээшлүүлэхэд дэмжих зорилготой дэлхийн хэмжээний томоохон сан юм. Монгол Улсаас Уур амьсгалын ногоон сангийн магадлан итгэмжлэлийг Хасбанк болон Худалдаа хөгжлийн банк аван уг зээлийг олгож байна.

Та байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа бол санхүүжилтийн боломжууд нэмэгдэж байгааг энэ удаагийн дугаартаа онцлон үлдээе.

СУДЛААЧИЙН ИНДЭР

АВСТРАЛИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН РЕФОРМ

Гүйцэтгэсэн: Гүйцэтгэсэн: Б.Наранжаргал¹, А.Бадамсүрэн², Б.Батчимэг³, А.Мөнгөнсаран⁴, Ц.Анударь⁵, Б.Дэлгөөн⁶

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.


САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

1990 оны санхүүгийн зах зээл

• Зах зээлийн нөхцөл байдал

Банкууд маш өндөр алдагдалтай байсан бөгөөд 1990 онд 9 тэрбум долларын алдагдалтай байсан нь ДНБ-ий 2.25 хувьтай тэнцэж байсан юм.

Зураг 5. 36. Банкны ашигт ажиллагаа, хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалтын өгөөж



Note: Profit figures are adjusted to exclude the government assistance provided to the State Bank Victoria (SBV) and State Bank South Australia (SBSA). Adjusted after-tax figures for 1990 and 1991 are unavailable due to the large transfers between SBV, SBSA and their state government owners.

Source: Banks' financial statements

1980–аад онд банкны зохицуулалтыг халснаас хойш өрсөлдөөн нэмэгдэж банкууд хөрөнгөө ихэсгэх эрмэлзэлтэй байв.

Энэ нь арилжааны үл хөдлөх хөрөнгийн үнийг эрчимтэйгээр нэмэгдүүлэхэд хүргэсэн. Үүний үр дүнд хэт өндөр үнэлгээтэй арилжааны үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан зээл өсөж эхэлсэн юм. 1989 онд бий болсон хүүгийн түвшин болон арилжааны үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлт зэрэг нь зээлийн чанарыг муудуулснаар эдийн засаг уналтад орж, хөрөнгийн үнэ буурч эхэлсэн ба зээлийн чанарын үзүүлэлтүүд улам муудаж эхэлжээ. Үүний дараа 1992 оны дунд үед чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ 6 хувьд хүрэн өссөн байв.

Иргэдийн санхүүгийн зах зээлд итгэх итгэл буурч эхэлсэн бөгөөд итгэлийг буцаан сэргээх үүднээс банкууд хүүгийн маржиныг өсгөснөөр өрхүүдийн зээлийн хэмжээ нэмэгджээ. 1992 онд өрхийн өрийн хэмжээ дор хаяж 10 хувиар нэмэгдсээр 1994 онд 17 хувьтай тэнцэж байв. Улмаар өрхийн өрийн болон орлогын харьцаа 2 дахин өсөж, 1994 онд өрийн орлогод эзлэх хувь 54 хувь байсан бол 1999 онд 100 хувьд хүрээд байсан.

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны зорилго нь 1980–аад онд эдийн засгийн удаашрал, хангалтгүй үзүүлэлтүүдээс шалтгаалан хийгдсэн Австрали улсын эдийн засгийн реформ бүхий л салбартаа хэрхэн хийгдсэн, ямар зохицуулалтууд нь амжилттай болон амжилтгүй хэрэгжиж, үр дүн яаж гарсан талаар дэлгэрэнгүй судалж өөрийн улсдаа ашиглах боломжтой үйл ажиллагааг хэрэгжүүлэх санал, дүгнэлт боловсруулах юм.

Судалгаанд Австрали улсын төрийн салбар, төрийн өмчит байгууллагын хувьчлал, түүнийг хийх болсон шалтгаан, үр дүн, харилцаа холбоо, төмөр зам, цахилгаан гэх мэт салбаруудад хийгдсэн дэд бүтцийн өөрчлөлтүүд, арга хэмжээ, өнгөрсөн болон одоо үеийн хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт, 1970–аас 2016 оны хоорондох мөнгөний болон сангийн бодлого, санхүүгийн зах зээлийн зохицуулалтын орчин, хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт хийгдсэн реформ, олон улс дахь амжилттай хэрэгжүүлсэн татварын зохицуулалт, жишээ зэрэг чухал агуулгуудыг багтааж дэлгэрэнгүй судаллаа.

Австрали улсын хувьд 1980–аад онд хийсэн эдийн засгийн реформын үр дүнд бүхий л салбартаа ололтыг авчирсан ба авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь олон улсад сайн практик жишээ болон үлджээ.

Түлхүүр үгс: Австрали улс, реформ, хувьчлал, зохицуулалт

JEL ангилал: E4, E5, E6, N1, N2, N3, N4, N5, P3

1 Судалгаа, эрсдэлийн шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн, naranjargal_b@frc.mn

2 Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, badamsuren@frc.mn

3 Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, batchimeg_b@frc.mn

4 Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн, mungunsaran@frc.mn

5 Хяналт шалгалт, зохицуулалтын газрын хянан шалгалт, anudari@frc.mn

6 Үнэт цаасны газрын мэргэжилтэн, dulguun_b@frc.mn

УУЛ УУРХАЙН САЛБАР

Олон улсын харьцуулалт

Дараах хүснэгтэд Африк, Ази, Латин Америкийн улсууд болон Австрали улсын уул уурхайн салбарт рояалти татварыг хэрхэн ногдуулдаг болохыг харууллаа.

	Гана	Өмнөд Африк	Хятад	Энэтхэг	Монгол	Баруун Австрали	Венесуэл
Хэлбэр	Үндэсний хууль	Аргачлалаар	Үндэсний хууль	Үндэсний хууль	Үндэсний хууль	Мужийн хууль	Үндэсний хууль
Рояалти татварын төрөл	Үнэ цэнд суурилсан	Үнэ цэн, борлуулалтын орлогод суурилсан	Нэгж, болон үнэ цэнд суурилсан	Нэгж, болон үнэ цэнд суурилсан	Үнэ цэнд суурилсан	Ихэвчлэн нэгж, үнэ цэнд суурилсан, алмазны хувьд ашигт суурилсан болон хайбрид	Үнэ цэнд суурилсан
Татварын түвшин	3–10%	3–12%	1–4%	0.4–20.0%	2.5% алтны хувьд 7.5%	2.5–7.5%	3–4%
Ашигт малтмал тус бүрээр ялгаатай эсэх	Үнэт чулуу: 10% Үнэт металл: 5% Бусад: 3%	Ялгаагүй	Ашигт малтмал тус бүрээр ялгаатай	Ашигт малтмал тус бүрээр ялгаатай	Ялгаагүй, зөвхөн алтны хувьд ялгаатай	Ялгаатай	Алт, мөнгө зэрэг металл: 3%, алмаз, үнэт чулуу: 4%, Бусад: 3%
Зэс	3%	3–12%	2%	3.2%	2.5%	Концентрац: 5% Металл: 2.5%	3%
Алт	5%	3–12%	4%	<2000 kg, US\$225/kg; >2000 kg, US\$235/kg	4–5%	2.5%	3%
Шохой чулуу	3%	3–12%	2%	55 рупи /тн	2.5%	0.30 Австрали доллар/ тн	3%
Нүүрс	5%	3–12%	1%	65–250 рупи/ тн	2.5%	7.5%	N/A

Уул уурхайн салбарт ногдуулсан татварын бодлого амжилттай хэрэгжсэн жишээ:

Австрали улс: Хөрөнгө оруулалтын орчинд татварын бодлого, газар зүй, геологийн нөхцөл, улс төрийн тогтвортой байдал зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Австрали улсын уул уурхайн салбар нь хөрөнгө оруулалтын таатай орчноороо дэлхийд тэргүүлдэг. Мөн рояалти татварыг муж тус бүр нь цуглуулдаг ба нэгжид суурилсан, үнэ цэнд суурилсан, ашигт суурилсан рояалти татварыг ногдуулдаг.

Рояалти татвар Баруун Австралийн хөрөнгө оруулалтын орчинд сөрөг нөлөө үзүүлэлгүй амжилттай хэрэгжсэн гол шалтгаан нь татварын түвшнийг эдийн засгийн үзүүлэлтүүдтэй харьцуулан тооцож ногдуулж байсантай холбоотой. 1997 онд анх рояалти татварыг 2.5 хувиар ногдуулж

байсан бол 1998 оны 6 дугаар сард алтны үнэ буурсан, зах зээлийн нөхцөл муудсан зэрэг шалтгаанаар 1.25 хувь болж бууруулсан. Харин 2000 онд татварыг 2.5 хувь болгож дахин өсгөсөн бол 2005 оныг хүртэл алтны үнийн бууралттай холбоотойгоор дахин 1.25 хувь болж бууруулсан. Өөрөөр хэлбэл Баруун Австрали рояалти татвар ногдуулахдаа тухайн үнийн түвшинд алт олборлож буй компани хангалттай хэмжээний ашигтай ажиллах боломжтойгоор алтны үнэ цэнд суурилсан татварын бодлогыг хэрэгжүүлж байжээ.

Рояалти татварыг хэрэгжүүлснээр алтны үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын түвшинд сөрөг нөлөө үзүүлээгүй бөгөөд нутгийн иргэдэд алтны үйлдвэрлэлийн түвшин, зах зээлд эзлэх хувиа бууруулахгүйгээр орлогоо нэмэгдүүлэх зэрэг эерэг нөлөөг үзүүлсэн юм.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Австрали улсад 1980 оныг хүртэл социалист эдийн засгийн дэглэм ноёрхож, эрүүл мэнд, санхүү, боловсрол, харилцаа холбоо, тээвэр зэрэг салбаруудыг төр эзэмшиж, гадаад худалдаа хаалттай, валютын тогтмол ханшийн систем үйлчилж байв. Үүний зэрэгцээ газрын тосны үнийн өсөлтөөс шалтгаалан Австралийн эдийн засаг уналтад орж, экспортын бууралт болон засгийн газрын өндөр зардлын нөлөөтэйгөөр эрэлт, нийлүүлэлтийн шок үүсэж, улмаар стагфляци бий болж, инфляци түүхэн дээд түвшиндээ хүрснээр засгийн газрын зүгээс эдийн засгийн томоохон салбаруудад реформуудыг хийх болов. Австралийн засгийн газар 1980, 1990 болон 2000–аад онуудад төрийн салбар, хөдөлмөрийн зах зээл, санхүүгийн зах зээл, хөдөө аж ахуй, уул уурхайн салбаруудад шинэчлэлүүдийг хийж эхэлсэн.

Төрийн салбарт менежеризм, төрийн шинэ менежмент, төр төвтэй засаглалыг хэрэгжүүлэх замаар иргэдийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хүргэж, өндөр чадавхтай боловсон хүчнийг бүрдүүлж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж, төрийн салбарт шинэ стандартуудыг нэвтрүүлсэн. Тухайлбал, Бүтээмжийн хороог байгуулснаар эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулахаас гадна нийгэм, байгаль орчин, эдийн засгийн харилцан хамаарлын асуудлыг хамарсан судалгаа, зөвлөмжийг гаргадаг болов. Мөн компаниудыг корпорацилал, хувьчлал гэсэн 2 хэлбэрээр хувьчилж эхэлснээр засгийн газрын өрийг бууруулж, эдийн засгийн хөгжлийг дэмжих түлхэц болж өгчээ.

Реформын хүрээнд зах зээлийн өрсөлдөөнийг идэвхжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Хөвөгч ханшийн системийг нэвтрүүлэх, хүүгийн түвшний таазыг цуцлах, банкуудад шинээр зөвшөөрөл олгох, мөн ашгийн татварыг бууруулах зэрэг санхүүгийн салбарт томоохон өөрчлөлтүүдийг хийж байсан бол аж ахуйн нэгжүүдийн хүрээнд монополь байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийх, харилцаа холбоо, төмөр зам, цахилгаан гэх мэт салбаруудад дэд бүтцийн шинэчлэлтүүдийг хийж байсан байна.

Түүнчлэн, реформ хийгдэж эхлэхээс өмнө тогтмол цалингийн систем буюу ажилласан цаг, бүтээмжээс үл хамааран бүх ажилчид ижил цалин авч, мөн цалингийн түвшин ажилласан цагаар бус нийт ажилчдын тоонд суурилан тогтоогддог байсан нь хөдөлмөрийн бүтээмжийг бууруулж байсан. Иймд хөдөлмөрийн зах зээл дэх реформыг эхлүүлж, илүү өрсөлдөөнийг дэмжсэн, хөдөлмөрийн нөөцийн үр ашигтай хуваарилалтыг хангасан зохицуулалтыг хэрэгжүүлж, мөн ажилтан ажил олгогчтой гэрээний нөхцөл, цалингийн хэмжээг харилцан тохиролцож болдог болов.

Санхүүгийн салбар дахь реформын хүрээнд тэтгэврийн санг байгуулснаар хөрөнгийн хуримтлал болон урт хугацаат хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үндэс бий болж, мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлснээр санхүүгийн зах зээлд өрсөлдөөн бий болж эхлэв. Үүнээс гадна санхүүгийн зохицуулалтын орчинд шинэчлэлт хийж, хоёр тулгуурт буюу "Twin Peaks" загварыг нэвтрүүлснээр зах зээлийн тогтвортой байдлыг хангах болон хөрөнгө оруулагч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх бүхий 2 тусдаа байгууллага үйл ажиллагаа явуулж санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжиж эхэлжээ.

Харин хөдөө аж ахуйн салбарт тус салбарыг дэмжих хүрээнд, байгаль хүрээлэн буй орчинг хамгаалахад чиглэсэн төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт олгох төрийн хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн байна.

Австралийн уул уурхайн салбар нь бодлого зохицуулалтын таатай орчноороо дэлхийд тэргүүлдэг бөгөөд хайгуул, олборлолт, боловсруулалт зэрэг уул уурхайн үйл ажиллагааны бүх шатанд уурхайчдын ашиг сонирхлыг хамгаалах хууль, эрх зүйн зохицуулалтыг системчлэн боловсруулсан байдгаараа маш онцлог.

Ийнхүү эдийн засгийн хөгжлийг дэмжигч томоохон салбаруудад реформыг хийсний үр дүнд Австралийн бүтээмж нэмэгдэн улсын эдийн засаг 1991 оноос хойш өнөөг хүртэл тасралтгүй 26 жил өсөлттэй байна.

ЭХ СУРВАЛЖ

- David Gruen and Amanda Sayegh, "The Evolution of fiscal policy in Australia", Australia, 2005,
- Paul Murphy, "Australian Superannuation System Overview", Australia, 2017
- Leslie Nielson and Barbara Harris, "Chronology of superannuation and retirement income in Australia", Australia, 2010
- Governor, Mr I.J. , "Monetary Policy Regimes: Past and Future", Australia, 1997
- Dr Martin Parkinson PSMSecretary to the Treasury, "Reflections on Australia's era of economic reform", Australia, 2014
- Rod Sims, "Australia's experience driving economic growth through competition policy reforms", Australia, 2013
- Department of the Parliamentary Library, "From There to Back Again?: Australian Inflation and Unemployment 1964 to 1993", Australia, 1994
- Economist's view, "The Australian Model", Australia, 2006
- Glenn Steven , "The Australian Economy: Then And Now", Australia, 2008
- Convict creation, "The Post-Socialist and Post-Capitalist Australian Economy", Australia
- Stephen Grenville, "The Evolution of Monetary Policy: From Money Targets to Inflation Targets" Australia, 1997
- Australian Competition & Consumer Commission, "Privatization of Public Enterprises and Utilities and Establishment

of Regulatory Framework", Australia, 1999

- Reserve bank of Australia "Privatisation in Australia", Australia, 1997
- Daniel C.H. Mah , "A Legal Perspective On Privatization In Australia", Australia, 1999
- ROGER WETTENHALL , "Privatization in Australia: How Much and What Impacts?", Australia, 1997
- Australian government, "BUDGET STRATEGY AND OUTLOOK 2013 14", Australia, 2014
- Paul Kelly, "The Politics of Economic Change in Australia in the 1980s and 1990s", Australia, 2000
- Kevin Davis , "The Australian Financial System in the 2000s: Dodging the Bullet", Australia, 2011
- Alexander Ballantyne, Jonathan Hambur and Ivan Roberts and Michelle Wright, "Financial reform in Australia and China", Reserve bank of Australia, 2014
- Marianne Gizycki and Philip Lowe, "The Australian financial system in the 1990s", Reserve bank of Australia, 2000
- Commonwealth of Australia, "THE RETIREMENT INCOME SYSTEM: REPORT ON STRATEGIC ISSUES", Australia, 2009
- Stephen P. King, "Why privatisation? A review of the Australian experience", Australia, 2015
- Allan Asher, "Privatization of Public Enterprises and Utilities and Establishment of Regulatory Framework", Bangkok, 1999
- National Farmers federation, "Mining And Petroleum Resources Policy", Australia
- Joann Wilkie and Angelia Grant, "The importance of evidence for successful economic reform", Australia
- Bill Russell and Warren J. Tease, "Employment, Output And Real Wages", Australia, 1988
- Ellis Connolly and David Orsmond, The Mining Industry: From Bust to Boom, Australia, 2011
- Mitch Hooke, Chief Executive Officer, Minerals Council of Australia, "Mining regulation in Australia", Australia
- Dr. David Gowland, "Privatisation In Australia In The 1990's: History And Social Conflicts Of Redistribution", Australia
- Economic Group, Reserve Bank of Australia, "The Australian Economy In The 1990s", Australia, 2000

- Ellis Connolly and Christine Lewis, "Structural Change in the Australian Economy", Australia, 2010
- Ric Battellino, Deputy Governor, "Twenty Years of Economic Growth", Australia, 2010
- Organisation for Economic Co-operation and Development, "Privatisation in the 21st Century: Recent Experiences of OECD Countries", France, 2009
- John Marsden, Marsden, Jacob and Associates, "Reforming Public Enterprises — Case Studies Australia", Australia, 1998
- Robin H Chambers, "An Overview of the Australian Legal Framework for Mining Projects in Australia", Australia,
- Anne Hawke and Mark Wooden, "Industrial relations reform in Australia: implications for the agricultural and mining sectors", Australia, 1998
- The Australian Council of Learned Academies, "Maintaining Australia's mining advantage", Australia, 2014
- Lynne Cockerell and Bill Russell, "Australian Wage And Price Inflation: 1971–1994", Australia, 1995
- Productivity commission, "Potential Benefits of the National Reform Agenda", Australia, 2006
- Agriculture and Agri-Food Canada, "Australia agriculture policy review", Canada, 2007
- Australian Bureau of Agricultural and Resource Economics and Sciences, "Australian agricultural productivity growth", Australia, 2014
- National Farmers Federation, "Food, Fibre & Forestry Facts", Australia, 2017
- Organisation for Economic Co-operation and Development, "Agricultural Policy Design and Implementation", 2008
- John Quiggin, "Economic Governance and Microeconomic Reform", Australia,
- Philip Maxwell, "Mineral Policy Lessons from Canada and Australia", Australia, 2002
- Gary Banks, "Minimum effective regulation' and the mining industry", Australia, 2003
- Department of Industry, Innovation and Science, "Resources", Australia, 2016
- Australian government, "Minerals And Petroleum In Australia", Australia, 2017
- <http://www.worldbank.org>
- <http://www.abs.gov.au>
- <https://www.rba.gov.au>
- <http://www.agriculture.gov.au>
- http://www.rtbu.com.au/_dbase_upl/52_2016-04-13_KDR.pdf
- https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Library/pubs/rp/rp9900/2000RP21
- <https://www.rba.gov.au/publications/confs/2000/dawkins.html>
- <http://www.iosco.org/library/pubdocs/pdf/IOSCOPD358.pdf>
- http://data.daff.gov.au/data/warehouse/agcstd9abcc002/agcstd9abcc0022017_lugZg/ACS_2017_v1.0.0.pdf



ӨРГӨН ДУРАН

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН НИЙГЭМЛЭГ (ALLIANCE FOR FINANCIAL INCLUSION)–ИЙН ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН 22 ДАХЬ УДААГИЙН ХУРАЛ 2020 ОНЫ 12 ДУГААР САРД ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР БОЛЛОО.


Хуралд СЗХ–ны дарга Д.Баярсайхан оролцож, коронавируст халдварт (КОВИД–19) цар тахлын улмаас үүсээд буй хүндрэл бэрхшээл, эрсдэлийг даван туулахад Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг ямар бодлого баримталж ажиллах, гишүүн байгууллагуудаа хэрхэн дэмжих, оролцогч талуудын чиг үүрэг, идэвх санаачилга зэрэг асуудлын талаар хэд хэдэн санал дэвшүүлсэн. Эдгээр саналтай холбогдуулж нийгэмлэгийн гишүүн байгууллагууд хамтран “КОВИД–19 халдварт цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулах нь” мэдэгдэл гаргаж, бодлого боловсруулагчдад зориулсан мэдлэг, туршлага солилцох, чадавх сайжруулах платформыг нэвтрүүлэхээр боллоо. Энэхүү платформ нь коронавируст халдварын дараах үеийн хямралыг давж гарах, нөхөн сэргээхэд чиглэсэн санхүүгийн хүртээмжийн бодлогыг хамтран боловсруулах, туршлага, мэдээлэл солилцох боломжийг гишүүн байгууллагуудад олгосноороо онцлог юм.

Хурлаар санхүүгийн үйлчилгээг нээлттэй, хүртээмжтэй болгоход чиглэсэн нийт 9 асуудлыг хэлэлцэж баталсны зэрэгцээ гишүүн улс бүрийн хэрэгцээ шаардлага, боломж, эрсдэл болон бусад хүчин зүйлсийг харгалзсан олон тулгуурт бодлого, зөвлөмжөөр хангах, гишүүн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай зөвлөлдөж, нийгэмлэгийн 2021 оны Байгууллагын стратеги төлөвлөгөө, 2020–2024 оны Чадавхыг бэхжүүлэх стратегид тусгав. Ингэснээр үндэсний тэргүүлэх чиглэл, хөгжлийн үзэл баримтлалдаа тулгуурлан гишүүн байгууллагууд өөрсдийн зорилго, хэрэгжүүлэх арга хэмжээ, үр дүнгээ тодорхойлох замаар техникийн туслалцааны төсөл хамтран хэрэгжүүлэх, бусад улсуудын туршлагаас суралцах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлэх зэрэг боломж бүрдэнэ.

Нийгэмлэгийн арга зүйн туслалцааны хүрээнд СЗХ Монгол Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030”–д тусгагдсан экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болох зорилт, “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө 2018–2021”–д тусгагдсан ногоон санхүүжилтийг дэмжих судалгаа хийх, зохицуулалтын орчин бүрдүүлэх, ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжсэн тогтвортой санхүүжилтийг

санхүүгийн зах зээлд төлөвшүүлэх зэрэг зорилттой уялдуулан “Зохицуулалттай этгээдүүдэд ногоон санхүүжилт нэвтрүүлэх нь” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн зорилго нь ББСБ–уудын ногоон санхүүгийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, ногоон компани, ногоон төслүүдэд зориулсан бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, таниулах, ногоон санхүүжилтийг бодлогоор дэмжих замаар санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах юм. СЗХ төслийг амжилттай хэрэгжүүлснээр нийгэмлэгийн тулгуур зарчмуудыг тусгасан “Мая”–ын тунхагт Хүртээмжтэй ногоон санхүү чиглэлээр тодорхойлсон зорилгоо биелүүлэхэд нэг алхам ойртохын зэрэгцээ салбарын хөгжилд түлхэц болохуйц бусад төсөл хөтөлбөр, санал санаачилгуудыг цаашид хамтран хэрэгжүүлэх, нийгэмлэгийн гишүүн орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх ач холбогдолтой билээ.

Дашрамд дурдахад, дэлхийн 88 орны нийт 100 төв банк гишүүнчлэлтэй энэхүү санхүүгийн хүртээмжийн бодлого тодорхойлогч олон улсын байгууллагад СЗХ 2010 онд гишүүнээр элссэн бөгөөд 2017 оноос СЗХ–ны дарга нийгэмлэгийн Захирлуудын зөвлөлийн гишүүнээр, 2020 оноос Зүүн Европ, Төв Азийн бүсийн санаачилгын дэд даргаар сонгогдон санхүүгийн хүртээмжийг сайжруулах бодлого тодорхойлох, тэдгээрийг хэрэгжүүлэхэд гишүүн орнуудын оролцоог дэмжих чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.



САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

СЗХ нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй төрийн байгууллага.

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан санал, дүгнэлт гаргаж хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ТӨРӨӨС САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ ХЭЛБЭР

1. Эрх зүйн зохицуулалт

Санхүүгийн зах зээлд оролцогч байгууллага өндөр үнэ тогтоох, хэт ашиг хөөх, хууль эрх зүйн акт зөрчих зэргээс хэрэглэгчийг хамгаалах зорилгоор дараах зохицуулалтыг хэрэгжүүлдэг.

- Хууль;
- Санхүүгийн бүртгэлийн стандарт;
- Тусгай зөвшөөрөлтэй холбоотой дүрэм, журам, төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, засаглал, ёс зүйн хэм хэмжээ, мэдээллийн тайлагнал.

2. Мэдлэг, мэдээлэл олгох замаар өөрийгөө хамгаалах чадварыг нэмэгдүүлэх

- Санхүүгийн хэрэглэгч нь мэдээллийн тэнцвэргүй байдлын улмаас сонголтоо буруу хийх, аль нэг талд эрх зүйн хувьд давуу байдал үүсгэх зэрэг нөхцөл үүсдэг.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ

Санхүүгийн хэрэглэгчийн эрх:

- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнаас эрх тэгш, ёс зүйтэй харьцахыг шаардах;
- Санхүүгийн байгууллагад өгсөн мэдээллийн нууцлалыг хангуулах, бусдад задруулахгүй байхыг шаардах;
- Үнэн зөв, тодорхой, цаг үеэ олсон мэдээллийг авах;
- Санхүүгийн байгууллагын мэдээлэл, ажилтны харьцаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар санал, гомдол гаргах;
- Өөрийн данс болон аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний гүйцэтгэлийн талаарх мэдээллийг авах;
- Таны худалдан авсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүү, шимтгэл, суутгал нэмэгдэх, хураамжид өөрчлөлт орох тохиолдолд урьдчилан мэдэх.

Үйлчилгээ үзүүлэгчийн эрх

- Гэрээний нөхцөл, заалтыг цаг тухайд нь биелүүлэхийг хэрэглэгчээс шаардах;
- Хэрэглэгчээс үнэн зөв мэдээлэл, шаардлагатай гэж үзсэн нотлох бичиг баримтыг гаргуулах;
- Бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
- Хэрэглэгчийн санхүүгийн нөхцөл байдал, орлого, зарлагын хэмжээ, нийгмийн статусын талаарх мэдээллээр бүрэн хангагдах.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧ, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

Санхүүгийн хэрэглэгчийн үүрэг:

- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрийн бүх зүйл заалт, нөхцөлийг анхааралтай унших, өөрт ойлгомжгүй зүйлийг лавлаж тодруулах, гэрээний зүйл заалтыг

бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрсөн тохиолдолд гарын үсэг зурж баталгаажуулах;

- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай аливаа гэрээ, хэлэлцээр байгуулахын өмнө болон хойно аль ч үед өөрийн санхүүгийн нөхцөл байдал, хүндрэлийн талаар мэдэгдэх, нотлох баримтыг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад гаргаж өгөх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг төөрөгдөлд оруулахуйц худал хуурмаг, бодит бус, дутуу мэдээллээр хангахгүй байх;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас авсан аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллээ бусдад задруулахгүй байж аюулгүй байдлаа бүрэн хангах арга хэмжээ авах.

Үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг:

- Хэрэглэгч бүрт эрх тэгш, шударга харилцах мэргэжлийн ёс зүйтэй байх;
- Хэрэглэгчийн санхүүгийн болон хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;
- Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах, хэрэглэгч бүрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон үйлчилгээг санал болгох;
- Хэрэглэгчийн гомдлыг үр дүнтэй, хурдан шуурхай, санхүүгийн чирэгдэлгүй барагдуулах дотоод тогтолцоотой байх;
- Хэрэглэгчийг санхүүгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, шаардлагатай мэдээллээр бүрэн хангах;
- Хэрэглэгч бүрд мэдээллийг ил тод, нээлттэй байдлаар хүргэх.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИД ХҮРГЭХ НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖ

- Санхүүгийн үйл ажиллагаа нь хоёр талт гэрээний харилцаагаар зохицуулагддаг тул үйлчлүүлэгчид гэрээ болон түүний хавсралтад заасан нөхцөлүүдтэй сайтар танилцахгүйгээр санхүүгийн гэрээг байгуулахгүй байх, санхүүгийн байгууллагын ажилтнаас уг гэрээтэй дэлгэрэнгүй танилцах боломж олгохыг хүсэх;
- Санхүүгийн үйлчилгээний гэрээг баталгаажуулсны дараа уг гэрээнд заасан өөрийн хүлээх үүргийг хариуцлагатайгаар мөрдөж, биелүүлэх;
- Санхүүгийн гэрээ болон аливаа төлбөр, даатгалын нөхөн төлбөртэй холбоотой бусад холбогдох баримтуудыг хадгалах.

МАРГААН ГАРСАН ТОХИОЛДОЛД ХЭРЭГЛЭГЧ ТАНЫ АВАХ АРГА ХЭМЖЭЭ

- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, санхүүгийн гэрээний маргаантай асуудал үүссэн тохиолдолд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын холбогдох ажилтанд хандаж, шийдвэрлүүлэх, уг шийдвэрийг эс зөвшөөрвөл СЗХ-нд хандан зөвлөгөө авах, шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргаж СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу СЗХ-нд хандан урьдчилан шийдвэрлүүлэх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотой маргаантай асуудлаар гаргасан СЗХ-ны шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийг дотор шүүхэд гомдол гаргах;
- Хэрэв маргаантай асуудлаар гаргасан шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНД АНХААРАХ АСУУДЛУУД /2-Р ХЭСЭГ/

Компанийн соёл

Хөрөнгө оруулагчдын өөр нэг анхаардаг зүйл бол компанийн соёл буюу энэхүү соёл нь хэрхэн үнэ цэнийг бий болгож, хадгалж хамгаалж байгааг харах юм. Компани соёлоо урт хугацааны стратегитай уялдуулах хэрэгтэй бөгөөд “биет бус хөрөнгө” (жишээлбэл, хүмүүн капитал ба соёл) нь компанийн зах зээлийн үнийн дүнгийн дунджаар 52 хувийг эзэлдэг болохыг судалгаагаар тогтоосон байдаг. Соёл нь компанид чадварлаг ажилтныг татах, бизнесийн гүйцэтгэлийг сайжруулах, урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэх зэрэг боломжийг олгодог. Ялангуяа тодорхойгүй байдал бий болсон үед компанийн соёл нь нэр хүндийн баталгаа болж, комплайнсын эрсдэлийг бууруулахад туслах төдийгүй бизнесийн уян хатан байдлыг сайжруулдаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх удирдлагуудтайгаа зөвшилцөн “tone at the top”-ийг тогтоож, ёс зүйн хэм хэмжээ, мэргэжлийн ур чадвар, шударга байдал, үйл ажиллагааны болон стратегийн аль алиныг нь хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол бүхий байгууллагын соёлыг бий болгохын төлөө ажиллах ёстой. Компанийн соёл нь компанийн зорилгыг тусгаж, түүний үндэс суурь болж өгөх ёстой. Компаниуд шийдвэр гаргахдаа байгаль орчны тогтвортой байдал, ажилчдын аюулгүй байдал, сайн сайхан байдал, олон талт байдал, хүртээмжтэй байдал, бусад үнэт зүйлийг харгалзан үзсэнээр цаашлаад эрсдэлийг бууруулж, урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхэд нэн чухал юм.

ESG (байгаль орчин, нийгэм ба засаглал) ба оролцогч талуудын засаглал

ESG нь “сайн засаглал”-ын хувьд төдийгүй бизнесийн стратеги, үнэ цэнийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд гол сэдэв хэвээр байна. ESG

ба үнэ цэнийг бий болгох хоорондын уялдаа холбоог судалж үзсэн McKinsey-ийн саяхны судалгаагаар ESG-ийн маш сайн гүйцэтгэл нь компаниудад шинэ зах зээл рүү нэвтрэх, одоо байгаа зах зээлээ өргөжүүлэх, тогтвортой байдлын стратегиар дамжуулан зардлыг бууруулах, зохицуулалтын болон эрх зүйн хөндлөнгийн оролцооны эрсдэлийг бууруулах, чадварлаг ажилтнуудаа хадгалах, ажилчдын бүтээмжийг нэмэгдүүлэхэд тусалдаг болохыг тогтоожээ.

“Үнэт зүйл” ба “үнэт зүйлс”-ийн хоорондын уялдаа холбоо нь компаниуд төдийгүй хөрөнгө оруулалтын нийгэмлэгийн бизнесийн шинэ стратегиудыг өдөөж байгаа бөгөөд үүнийг ESG болон тогтвортой хөрөнгө оруулалтын сангуудад сүүлийн үед орж ирж буй хөрөнгийн урсгал харуулж байна. Сүүлийн үеийн судалгаагаар ESG-ийн өсөлттэй багцууд энэ оны эхээр зах зээлийн огцом уналтын үед ESG тогтвортой бус өрсөлдөгчдөөсөө ерөнхийдөө илүү гүйцэтгэлтэй байсныг харуулж байгаа бөгөөд Европт чиглэсэн PricewaterhouseCoopers судалгаагаар судалгаанд хамрагдсан 300 байгууллагын хөрөнгө оруулагчдын 75-аас дээш хувь нь ойрын хоёр жилийн хугацаанд ESG стандартад нийцэхгүй уламжлалт хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнд хөрөнгө оруулахаа зогсооно гэжээ.

ESG нь стратегийн болон үйл ажиллагааны шийдвэр гаргах түвшинд улам бүр нэмэгдэж байгаа бөгөөд нэгдэх нийлэх хүрээнд илүү ажиглагдах болно. Жишээлбэл, илүү технологи руу шилжих эсвэл бүтээгдэхүүнийхээ аюулгүй байдлыг сайжруулах замаар бизнесийнхээ тогтвортой байдлыг дээшлүүлэхийг эрмэлзэж буй компаниуд нэгдэх нь стратегийн хувьд зайлшгүй шаардлага болж байгааг олж мэднэ. ESG хэмжүүрүүдийн шаардлага, хариуцлагатай байдал улам бүр нэмэгдсээр байгаа тул эдгээр хэмжүүрүүд нь магадлан шинжилгээ болон боломжит гүйлгээний нөлөөллийг урьдчилан үнэлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.



Мөн ESG-ийн өгөгдлийг хянах, нээлттэй мэдээлэх талаар компаниуд илүү их зүйл хийх, илүү ихийг хэлэх ёстой болсон нь тодорхой байна. Хөрөнгө оруулагчид (үүнд идэвхтнүүд орно) болон тодорхой итгэмжлэгдсэн зөвлөхүүд ТУЗ-ийн хяналт, ESG-ийн хүчин зүйлсийн хариу үйлдлийг идэвхтэй ажиглаж, компанийн ESG-ийн гүйцэтгэлийг харьцуулж байна. Жишээлбэл, БлэкРок өнгөрсөн долдугаар сард цаг уурын өөрчлөлттэй холбоотой эрсдэлд бизнесээ бэлтгэх, хөрөнгө оруулагчдад мэдээлэх чиглэлээр хангалтгүй ажиллаж байгаа 244 компанийг 2020 онд мэдээлсэн. Мөн эдгээр компанийн 22 хувьд нь захирлуудын эсрэг санал өгсөн гэж мэдэгдсэн бөгөөд үлдсэн 78 хувь нь дараа жил нь ахиц дэвшил гаргахыг ажиглана гэжээ. Нэмж дурдахад, Гласс Льюис 2021 оноос эхлэн байгаль орчин, нийгэмтэй холбоотой асуудал, эрсдэлийн талаарх ТУЗ-ийн түвшний хяналт шалгалтын талаар тодорхой тодруулга өгөөгүй S&P 500 компаниудыг 2022 оноос эхлэн анхааралдаа авах болно гэж мэдэгдэв. Ерөнхийдөө ийм тодруулга өгөөгүй компаниудын засаглалын хорооны даргын эсрэг санал өгөхийг зөвлөж байна.

ESG-ийн хэмжүүрүүд илүү стандартчилагдах тул энэхүү хариуцлага нь улам хурдасна. Үүнтэй холбоотойгоор зөвшилцөлд хүрэх хандлагыг баримтлах хэд хэдэн чухал үйл явдал өнгөрсөн онд гарсан. 9-р сард Дэлхийн эдийн засгийн форумын Олон улсын бизнесийн зөвлөлөөс нягтлан бодох бүртгэлийн томоохон 4 фирмтэй хамтран нийтэд мэдээлэх хүрээний эцсийн зөвлөмжийг гаргасан. Саяхан Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB) ба

Олон улсын тайлангийн нэгдсэн зөвлөл (IIRC) нэгдэж, Нэмэгдсэн Тайлангийн Сан хэмээх шинэ байгууллага байгуулснаа зарлаж, IIRC-ийн нэгдсэн тайлангийн хүрээг SASB-ийн мэдээллийн стандарттай уялдуулах болжээ. Олон томоохон институцийн хөрөнгө оруулагчид конвергенцийг бий болгохын тулд тодорхой ажлын хүрээг баталсан. Энэ ахиц дэвшил гарсан хэдий ч ESG-ийн талаарх олон тооны бүтэц, хэмжүүрийг эрэмбэлэх нь томоохон компаниуд тэдгээрийн төлөөлөн удирдах зөвлөлийн асуудал хэвээр байх болно.

“ESG-ийн чадварлаг” ТУЗ-ийн хүлээлт үргэлжлэн өөрчлөгдөж, хөгжиж байгаа тул захирлууд гүйцэтгэх удирдлагатай хамтран компанид тулгараад буй ESG-ийн эрсдэл, боломжуудыг олж тогтоох, тайлагнах, хянах хангалттай үйл явцыг хангаж, эдгээрийг компанийн стратегийн болон үйл ажиллагааны шийдвэр гаргахад авч үзэх хэрэгтэй. Зарим тохиолдолд энэхүү хяналтын чиг үүргийг ТУЗ-ийн түвшинд хэрхэн зохион байгуулж хуваарилах, жишээлбэл, ТУЗ-ийн хороог шинээр байгуулах эсвэл одоо байгаа хорооны бүрэн эрхээ сайжруулах замаар тодорхой ангиллын ESG эрсдэлийг илүү нарийвчлан шийдвэрлэх замаар тохируулах эсвэл холбогдох ESG-ийн туршлагатай шинэ захирлуудыг ажилд авах нь зүйтэй.

ТУЗ нь гүйцэтгэх удирдлагатай хамт ESG-ийн талаарх хэтийн төлөв, тэргүүлэх чиглэлээ ойлгохын тулд хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талуудтай холбоо тогтоож байх ёстой. Компани ESG-ийн зорилгоо тодорхойлж, ажиллуулахын тулд ялангуяа хувьцаа эзэмшигчдийн дэмжлэг чухал хэвээр байх болно.

Үргэлжлэл бий...

Эх сурвалж: Harvard Law School Forum on Corporate Governance



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

БҮС НУТГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

Цар тахлын улмаас дэлхийн эдийн засаг түүхэн дэх томоохон хямралд орлоо. Хөгжингүй орнуудад 2020 оны II улирлын байдлаар эдийн засгийн үйл ажиллагаа бараг зогсонги байдалд орсноор санхүүгийн болон мөнгөний хүрээнд бодлогын чухал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхэлсэн. Гэсэн хэдий ч, дараагийн хагас жилийн сэргэлтийн үед хөгжингүй эдийн засаг нь эдийн засгийн хямралын өмнөх түвшинд хүрч чадаагүй юм. Дотоодын эрэлтийн сэргэлт ерөнхийдөө тодорхойгүй байдал, цар тахлын байдлаас болж эдийн засгийн үйл ажиллагаанд саажилт үзүүлснээс болж эмзэг болсон. Үүний эсрэгээр өсөлтийн чиг хандлага нь бодлогыг дэмжих арга хэмжээнээс ихээхэн хамааралтай хэвээр байна.

Хөгжингүй эдийн засагтай орнууд хамгийн хүнд цохилтод оров.

2021 онд хөгжингүй орнуудын эдийн засаг сэргэх төлөвтэй байсан боловч энэ төлөв нь тодорхойгүй эргэлзээтэй болсон. АНУ-д мөнгөний зөөлөн бодлого үргэлжилж байгаа тул удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний хэрэглээ болон орон сууцны хөрөнгө оруулалт нэмэгдсээр байна. Гэсэн хэдий ч, КОВИД-19 цар тахалтай холбоотой тодорхойгүй байдал хэвээр байгаа тохиолдолд ялангуяа аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт, экспортын хэмжээ сул хэвээр байх төлөвтэй байна. Хөдөлмөр эрхлэлтийн хэтийн төлөв, цалин хөлсний өсөлт сул байгаа нөхцөлд төсвийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ хангалтгүй хэвээр байвал эмзэг байдлын сэргэлт нь амархан буцаад доошлох боломжтой. АНУ болон бусад хөгжингүй эдийн засагтай орнуудын өрхийн хадгаламжийн өсөлт тодорхой бус байдалд ороод байна. Европын хэтийн төлөвт учрах эрсдэлийн тоонд цар тахлын цаашдын хувьсал, халдвартай хүмүүсийн тоог шийдвэрлэх зорилгоор IV улиралд авсан хорионы арга хэмжээ орно. Хөгжингүй Азид хэтийн төлөв нь гадаад эрэлт, ялангуяа Зүүн Азийн эрэлт сэргэхээс ихээхэн хамааралтай байдаг. Дэлхийн нийлүүлэлтийн сүлжээ, түүхий эдийн эрэлт, аялал жуулчлалын тогтвортой байдал нь эдийн засгийн гүйцэтгэлийг тодорхойлох чухал хүчин зүйл болно.

Түүхий эдийн үнэ буурсан нь Тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөл ба Гүржийн хувьд бэрхшээлийг улам хүндрүүлэв.

КОВИД-19 цар тахлын дэгдэлт нь Тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөл, Гүржид олон цочролыг авчирсан. Цочрол бүс нутаг даяар өргөн тархсан тул бараг бүх улс оронд үйлдвэрлэлийн хэмжээ буурчээ. Эдгээр бууралтын хэмжээ нь тухайн улсын эдийн засгийн бүтэц, нөхөн олговрын арга хэмжээ авах чадвараас хамаарч эрчим хүч экспортлогч орнуудад илүү том байсан. Бүс нутгийн эдийн засгийн төлөв тодорхойгүй байгаа бөгөөд цар тахлын цаашдын чиг хандлагыг багтаасан сөрөг үр дагавар давамгайлж байна. Өнөөгийн хямралын үед банкны салбар тогтвортой хэвээр байгаа боловч олон оронд активын чанар муудаж, долларжилтын түвшин өндөр байгаа нь зээлийг хязгаарлаж, эрсдэлийг нэмэгдүүлэх болно. Нэмж дурдахад геополитикийн хурцадмал байдал газар авч, зарим тохиолдолд жинхэнэ зөрчилдөөнд хүргэсэн.

Зүүн Өмнөд Европ нь ажилгүйдэл ихтэй, худалдааны уялдаа холбооноос үүдэлтэй сөрөг нөлөөлөлтэй тулгарав.

Зүүн Өмнөд Европт хямралын улмаас ажилгүйдэл аль хэдийн өндөр түвшнээс өсөж, өмнөх жилүүдэд ажиглагдаж байсан зарим өсөлтийг бууруулав. Бүс нутгийн экспортын гол чиглэл, хөрөнгө оруулалт, мөнгөн гуйвуулгын эх үүсвэр болох Европын Холбоонд болсон цар тахлын

гамшиг нь гадаад эрэлт болон орлогыг бууруулж, нийлүүлэлтийн гинжин хэлхээний тасалдал нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сааруулж байна. Аялал жуулчлал, хараат байдлын түвшингээс хамааран бүс нутагт үр нөлөө нь харилцан адилгүй байна.

Африкт сүүлийн хэдэн арван жилийн хөгжлийн амжилтыг эргүүлэн доош нь татах ноцтой эрсдэл тулгарч байна.

Африк тивийн урт хугацааны хөгжилд томоохон сөрөг нөлөө үзүүлэх түүхэнд байгаагүй эдийн засгийн уналтыг мэдэрч байна. Цар тахлыг хянахад шаардагдах дотоодын хорио, гадаад эрэлт буурч, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өсөж, аялал жуулчлал унаж, мөнгөн гуйвуулга буурсан нь эдийн засагт ноцтой хямралыг бий болгосон. Африкийн олон улс орнууд цар тахлын тархалтыг зогсоохын тулд хурдан арга хэмжээ авсан боловч ихэнх нь эрүүл мэндийн тогтолцоог дэмжих, хүн амын эмзэг бүлгийг хамгаалах, нөхөн сэргээхэд шаардлагатай нөөц бүрдүүлэх асуудал хомстолтой тул бэрхшээлтэй тулгарсан. Өнөөгийн хямрал нь ажилгүйдэл, ядуурал, тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлж байгаа бөгөөд энэ нь сүүлийн хэдэн арван жилийн хөгжлийн ололтыг устгах аюулд хүргэж байна. Нэмж дурдахад улсын өрийн хэмжээ өсөж байгаа нь Африкийн олон улс орнуудыг өрийн дарамтад оруулж санхүүгийн хүнд байдалд оруулж байна. Тус тив 2021 онд бага зэрэг сэргэх төлөвтэй байгаа боловч дотоод хориог зөөлрүүлж, худалдаа, түүхий эдийн зах зээл сайжрахаас энэ бүгд хамаарна.

Зүүн Азийн эдийн засаг бусад бүсээс дээр байдалтай байна.

Зүүн Ази 2020 онд эдийн засгийн өсөлт огцом саарч, Азийн санхүүгийн хямралаас хойш тус бүс нутгийн хамгийн сул эдийн засгийн байдалд очсон юм. Дотоодын дэгдэлтийг хязгаарлах, түүний дотор хөдөлгөөнийг хязгаарлах, аж ахуйн нэгжүүдийг албадан хаах зэрэг арга хэмжээнүүд нь өрхийн орлого, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрс багасгасан. Бүс нутгийн хөрөнгө оруулалтын хэтийн төлөв тодорхойгүй байдал, эрсдэлээс зайлсхийх буурах зорилгоор дотоодын эрэлт хэрэгцээнд дэмжлэг үзүүлж зарим сөрөг үр дагаврын нөхөхөд туслах бодлогын томоохон арга хэмжээнүүд авсан. Гэсэн хэдий ч нийлүүлэлтийн тасалдал, дэлхийн эдийн засгийн үйл ажиллагаа суларснаас экспортын хэмжээ агшиж, гадны талаас нэлээд сөрөг уналт гарсан. Бүс нутгийн олон хэсэгт цар тахлын улмаас нийгэм, эдийн засгийн хөгжилд томоохон ухралт гарч, нийгмийн эмзэг давхаргад харьцангуй ихээр нөлөөлж байна.

Баруун Ази нь эрчим хүчний үнэ бууралт, аялал жуулчлалын орлого багасах зэрэг бэрхшээлтэй тулгарав.


Баруун Азид цар тахал, түүнийг бууруулах арга хэмжээнүүд бүс нутгийн хэмжээнд эдийн засгийн үйл ажиллагааг зогсонги байдалд оруулав. Цар тахлын нөлөө нь бүс нутгийн өндөр үзүүлэлттэй аялал жуулчлалын салбарт хамгийн их мэдрэгдэж байсан бөгөөд энэ нь орон байр, тээвэр, бөөний болон жижиглэнгийн худалдааны үйлчилгээ ихээхэн сулрахад хүргэсэн. Үүний зэрэгцээ эрчим хүчний зах зээлийн өсөлтгүй сул байгаа нь түүхий эдийн экспортлогчдын орлогыг боомилж, төсвийн бодлогын хувилбаруудад нэмэлт хязгаарлалтыг үүсгэжээ. Бүс нутгийн эдийн засгийн сэргэлт нь дэлхийн эрчим хүчний эрэлт хэрэгцээ, олон улсын аялал жуулчлал, төсвийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний үндсэн дээр дотоодын эрэлт хэрхэн сэргэх зэргээс хамаарна.

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

S&P 500 /^GSPC/


3,971.09 -3.45 (-0.09%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


29,323.34 -60.71 (-0.21%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


6,736.17 -4.42 (-0.07%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

13,059.65 -79.08 (+0.60%)



Эх сурвалж: www.Bloomberg.com

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160

+976-51-264444

press@frc.mn

www.frc.mn

Санхүүгийн зохицуулах хороо

@FRC_of_Mongolia